

Нэг.

# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ

## АРДЫН ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ЗАРЛИГ

1995 оны 4 дүгээр  
сарын 14-ны өдөр

дугаар 79

Улаанбаатар хот

Улаанбаатар хотод засаг захиргааны  
район байгуулах тухай

Нийслэл Улаанбаатар хотын аж ахуйн соёлын байгуулалтын өсөлт хөгжлийн шаардлагыг харгалзан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс тогтоох нь:

1. Нийслэл Улаанбаатар хотын АДХ-ын харьяа Ажилчин, Найрамдал, Амгалан, Зүүн сэлбэ, Сүхбаатар, Хоршоолол, Чингэлтэй, Толгойт, Октябр, Төмөр замын хороодыг татан буулгаж Сүхбаатар, Октябрь, Ажилчин, Найрамдлын район байгуулсугай.
2. Нийслэл Улаанбаатар хотын районы АДХ-ын сонгуулийг орон нутгийн хурлын 7 дахь удаагийн сонгуультай хамтатган явуулсугай.

БНМАУ-ын Ардын Их Хурлын  
Тэргүүлэгчдийн дарга Ж.Самбуу

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн  
нарийн бичгийн дарга Ц.Готов

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 4 дүгээр  
сарын 25-ны өдөр

дугаар 24

Улаанбаатар хот

Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг  
шинэчлэн тогтоох тухай Монгол Улсын Их Хурлаас  
ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг 1 дүгээр хавсралтын ёсоор, түүний дүүргүүдийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.
2. Нийслэлийн хилийн цэсийг баталсантай холбогдуулан Төв аймгийн Алтанбулаг, Аргалант, Эрдэнэ, Сэргэлэн, Баяндэлгэр, Баян, Баянчандмань сумдын хилийн цэсийг шинэчлэн боловсруулж Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1982 оны 131 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Дарга Н.Багабанди

**7. Хан-Уул дүүрэг**

Сонгинохайрхан уул /1652.3/, Сонгино уулын хойд толгой, Залаа уул /1562.0/, Жаал толгой, Сонгины булан, Туул голыг өгсөж Сонголонгын гүүр, Туулдунд голын бэлчир, Дунд голын хойд далангаар нь өгсөж Дунд гол Марксын гудамжны машин замын огтлолцол, Марксын гудамжны хар замыг баруун талаар нь уруудаж Их тэнгэрийн амны Туул голын гүүр, Бага тэнгэр уул, Их тэнгэр уул /1731.3/, Сэнж цохио, Их ёл уул, Улаан асгат /1855.0/, Зүрх уул /1683.8/, Баруундэлгэр уул /1893.0/, Төв уул /1822.5/, Нам даваа, Шар хөвийн хяр, Ханан уул /1683.8/, 1601.1, 1685.9 тоот Тоорой шандын уул, Богино хөтөл /1419.0/, Сүүл даваа /1494.0/, Ташгайн даваа /1347.0/, шон №6, №7, №8, №9, №10, №11, Хөндлөн уул /1402.0/, Салхит уул /1417.0/, 1348.0 тоот, Сайр худаг 1474.0 тоот, Сонгинохайрхан уул хүрнэ.

## ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ГАЗАРЗҮЙН ЗУРАГ




## ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ, ҮҮСЭЛ ХӨГЖЛИЙН ТОЙМ

### A. Нийслэл хотын суурьших газрыг сонгосон тухай

Халхын Түшээт хан Гомбодоржийн зөвгүүн Занабазарыг 1639 оны шарагчин туулай жил Монголын шарын шашны “Өндөр гэгээн” хэмээн өргөмжилж түүнд зориулан адоогийн Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутаг “Ширээт цагаан нуур” хэмээх газарт Шар бөсийн орд барьж суулгаснаар Их Хүрээ буюу одоогийн нийслэл Улаанбаатар хотын үндэс суурь тавигдсан түүхтэй билээ. Хүрээ нь ийнхүү 1639-1672 онд Ширээт цагаан нуурт суурьшиж байгаад 1672-1686 онд Архангай аймгийн Өгий нуур сумын нутаг “Улаан худаг”-т суурьшиж байх уед Галдан Бошигтын түрэмгийлэлд өртөж тэндээсээ нүүж одоогийн Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг “Хийдийн сарьдаг” гэдэг газарт суурьшсан байна. Хүн очихын аргалтүү битүү шугуйтай энэ газарт 2 жил орчим болжээ.

Үүний дараа Өвөр Монголын нутаг Долнуурт арваад жил суурьшиж байсан судалгаа бий юм. Эрдэмтэн судлаачдын тогтоосноор Монгол улсын Нийслэл хот нь 1706 оноос 1855 он хүртэлх 150 шахам жилийн дотор 20 орчим удаа буурь сэлгэж Архангай, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Хэнтий зэрэг аймгуудын нутагт суурьшиж байсан түүх бий. Үүнд: 1706 онд Архангай аймгийн Цэцэрлэгийн Эрдэнэ толгойд, 1719 онд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Дааган дэлд, 1720 онд Сэлэнгэ аймгийн Орхон голын зүүн цутгал болох Усан сээрт, 1722 онд Архангай аймгийн Тамирт, 1723 онд Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нутаг Амарбаясгалант хийдийн баруун тал, Төв аймгийн Жаргалант сумын нутаг “Дэлгэр булагт, дараа нь Сэлэнгэ аймгийн Ээвэн голд, 1724 онд Төв аймгийн Угтаал, Жаргалантад, дараа нь дахиад Ээвэн голд, 1729 онд Хужирбуланд буюу Жаргалантад, дараа нь Бургалтайд, 1732 онд Сөнгөгөрт, 1733 онд Тэрэлжид, 1734 онд Улиастайд, 1736 онд Хүй мандалд, 1740 онд Хунцалд, 1742 онд Үдлэгт, 1743 онд Өгөөмөрт, 1747 онд Сэлбэд тус тус суурьшиж байгаад дахин хэдэнтээ буурь сэлгэсэн байх агаад 1855 онд



Соёмбөт толгой

дахин Сэлбэ голын хөвөөнд эргэн суурьшаад өнөө хүртэл тогтвортой суурьшсан байна. Ийнхүү Их Хүрээ суурьшмал байдалтай болж олон тооны сүм хийд барих болсон нь Монголын архитектурын хөгжлийн шинэ хандлагыг бий болгосон гэж үздэг. 1911 онд VIII Богд Жавзандамбыг хаан ширээнээ залж Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улсыг түнхаглахын зэрэгцээ Их Хүрээг сэргээн байгуулагдсан Монгол улсын Нийслэл хот хэмээн нэрийдэх зарлиг буулгажээ. Богд хааны тэрхүү зарлигт: “Одоо манай улсын бүгдээр бараалхан хуралдах газар бол Очирдарь Богд эзэн хааны залран суугаа Нийслэл хүрээ даруй мөн бөгөөд манай улсын чухамхуу эрхэмлэвээс зохих охь манлай ундэс газар мөн” гэж хуульчлан баталжээ. 1921 оны Үндэсний тусгаар тогтолын хувьсгалын ялалт нь Нийслэл хүрээний дотоод амьдралд ихээхэн нөлөөлжээ. Хүрээнд энгийн иргэд ирж суурьших нь элбэгшиж хашаа, байшин баригдах болсон байна. Тэр үеийн Их Хүрээний бүтэц, зохион байгуулалт нь дараах хэсгүүдтэй байжээ. Үүнд:

Зүүн хүрээ, Гандан, Баруун дамнуурчин, Зүүн дамнуурчин, Маймаа хот, Хүрээний харчууд, Хорооны харчууд, Консул сайдын Яам, Дамбадаржaa гэж хуваагдаж байсан байна.

Дэчингалав богдын ордны цогцолборын баруун урд талаас эхлэн түүний араар тал дугуй тойрог маягаар Их Хүрээний 30 аймаг байрлаж байжээ. Үүнд: Шүтээний, Дондовлин, Жадарын, Тоймслонгийн, Дүйнхорын, Цэцэн тайны, Андуу нарын, Дандарлин гийн, Маяагийн, Жасын, Номчын, Сангайн, Зоогойн, Дугарын, Чойнхорлонгийн, Хамбын, Ноёны, Дархан эмчийн, Эрхэмийн, Эх дагиньи, Вангайн, Хувилгааны, Баргын, Надилингийн, Бадидын, Сүмбийн, Лам нарын, Номун ханы, Орлуудын гэсэн дараалтай байжээ.

Их Хүрээний баруун дамнуурчны хятад хороолол үүссэнд дараа үүнээс улбаалан Гандантэгчилэн хийдийн анхны суурь таваигдсан түүхтэй юм. 1837-1840 оны орчимд V Богд Жавзандамба хутагтын зуны

ордон буюу Гунгаадэжидлиin хэмээх Туулын цагаан сүмийг барьж VI, VII, VIII дугаар Богд хаадуудын зуслангийн ордон болгон ашиглаж байжээ. Ийнхүү Богд хутагтууд нь 1838 оноос хойши шашин, төрийнхөө үйл ажиллагааг зуны цагт Зүүн хүрээний төв дунд байсан шар ордон болон баруун өргөөнөөс, өвлүйн цагт Гандантэгчилэн хийдээс тус тус явуулж байсан байна.

1893 онд Зайсангийн богиных амны эсрэг талаас Туул голд цутгадаг булгийн хойдох довны орчимд VIII дугаар Богд Жавзандамбад зориулж Шаравпэлжээлиin хэмээх ногоон паалантай дээвэртэй сүм барьж энэ үеэс Богд хаан энд өвөлждөг болсон учир Богдын ногоон сүм буюу ногоон лаврин гэж нэрлэх болжээ. 1903 онд Шаравпэлжээлиin сүмийн зүүн талд Богд хааны хоёр давхар орос байшинг барилсан бөгөөд Богд Жавзандамба хаан өвөл, зунгүй Туулын хөндийд суурьших болжээ. Энэ үеэс Гунгаадэжидлиin хэмээх цагаан сүмийн газарт анхдугаар Богд өндөр гэгээн Занабазарын түүх намтартай холбогдох зүйлийг хадгалсан сүм, олон нийтийн мөргөлийн газар болжээ. Мөн түүнчилэн VIII дугаар Богд Жавзандамба хутагтын өдөр дутмын хэрэгцээний сүү, цагаан идээ, мах, хүнсэнд зориулсан 1,1 сая орчим толгой мал сүргийн дотроос цөөн тооны шилмэл сүргийг Богдын лаврингийн дэргэд ойролцоо газартmallадаг байжээ. Энэ газар нь Туул, Дунд голын хоорондох газар бөгөөд “Өндгөн сүргийн нутаг” болгон зарлиг буулгасан тул Богдынхоос өөр айл суух, мал билчээрлүүлэх, морь аргамжихыг хатуу хориглож байжээ. Өндгөн сүргийн нутагт Богд хааны хадам эцэг хэмээх Сэцэн хан аймгийн Жонон ван Цогбадрахынх, Сайн ноён хан Намнансүрэнгийнх, Анихдугаар богд Өндөр гэгээн Г.Занабазарыг хөхүүлж өсгөсөн “Сүүн далай ээж” –ийнхээс өөр айл суудаггүй байжээ. Богд хаан болон түүний гэр бүл, бараа бологсад, хол газрын зочин гийчдэд сонирхуулах зорилгоор Ногоон сүмийн зүүн урд талд Норвлин хэмээх сүм барьж тус сүмийн газарт халуун орны анааш, сармагчин, заанаас авахуулаад буга, согоо, баавгай зэрэг амьтадыг тэжээн

амьд амьтны хүрээлэн байгуулжээ. VIII дугаар Богд хааныг хаан ширээнд сууснаас хийш Монголд анх удаа 1912 онд Богд хааны ундны усны худгийг тус ордны дэргэд гаргасан байна. Энэ үеэс эхлэн 1914-1915 оны хооронд Их Хүрээнд олон тооны худгуудыг гаргажээ. Богд хааныг хамгаалах төрийн алба буй болж “Богдын шадар цэргийн хуаран”-гийн газрыг 1905 онд өвлийн ордны баруун талд байгуулж Их Хүрээний Цагдан сэргийлэх газар бий болсон байна. Цагдан сэргийлэх газар нь Богдын ордонг хамгаалах, Богд уул болоод Өндгөн сүргийн нутгийг харгалзах үүрэгтэй ажиллаж байжээ.

Монгол улс манжийн дарлалд 220 гаруй жил дарлагдаж байгаад 1911 онд үндэсний эрх чөлөөний тэмцлээр манжийн дарлалаас ангижирч Бүрэнэрхт Монголулыг байгуулж 1911 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баасан гаригт Богд Жавзандамба хутагтыг Монгол улсын шашийн төрийг хослон баригч эзэн хаанаар өргөмжилсөн байна. Энэхүү хүндэтгэлд зориулж Монголын хамгийн том хүндэтгэлийн хаалтыг бариулсан бөгөөд энэ хаалга нь эдүгээ Богд хааны ордон музейн цогцолборт багтдаг. Монгол улс тусгаар тогтоносны билэгдэл болгож Халхын Сайн ноён хан аймгийн Далайчойнхор вангийн хошууны дархан Дашаагийн Шар гэдэг хүн Монгол улсад хамгийн том нэг метрийн диаметртэй дүүжин цаг хийж Богд хааны зуны ордонд байрлуулжээ.

Богд хааны зарлигаар зураач Жүгдэр гэдэг хүн 1912 онд Их Хүрээний зургийг Зайсан толгой дээрээс харж зурсан нь одоо хааны музейд хадгалагдаж ирсэн байна. Газар, нутгийг шинжих дээдсийн ухаан хичнээн агуу байсны нэг тоджишээ бол, 1966 оны 7 дугаар сард болсон аймшигт үерийн үеэр Туул голын хөндий тэр чигээрээ усанд автаа нэлийж байхад ганцхан Богдын ногоон музей ордон яагаа ч үгүй, хув хуурай нэмцийж байсан гэдэг юм. Үүнийг харсан хүмүүс одоо ч байсаар байгаа билээ.

Монгол улсын түүхнээ анх Нийслэл хот үүсгэн байгуулагдсан “Ширээт цагаан нуур”-т 1999 онд дурсгалын гэрэлт хөшөөг

босгосон бөгөөд 2003 онд сэргээн засаж тохижуулах ажлыг гүйцэтгэсэн байна.

**Б. Одоогийн Нийслэл хот-Улаанбаатарын сүүрьших газрыг хэрхэн шинжиж байгуулсан тухай эртиээс дамжиж ирсэн домгоос сонирхуулая.**

Тэртээ 14 дүгээр жарны эхэн үед Тавдугаар Богд Лувсанчүл-тэмжигмэд /1815-1841 онд амьдарч байсан/ нэгэн шөнө нойрсож ахуйдаа “Бавуумарав” гэдэг нэгэн их хүмүүн том цагаан заан унаад явж байхтай нь таарадлав гэнэ.

“Та ямар хэргээр энд явж байна вэ?, Нутаг хаана бэ?” гэж асуухад тэр их хүмүүн хариуд нь “Богд хаан ууланд дуган сүм байгуулах зохистой газар эрж явна” гэж хэлээд алга болчихож гэнэ. Тэгээд Богд Лувсан чүлтэмжигмэд мэргэдээс асууж “зүүд тайл” гэсэн гэнэ.

Мэргэд хариуд нь:

“Богд та, энэ шар дэнжид сүм хийдээ байгуулбал өлзийтэй, таны их хүрээ удахгүй 18 төрлийн үйлдвэртэй, шөнийн дуу тасардаггүй хүн амьтантай “Бавуу Марав” гэдэг нэртэй том хот болох юм байна” гэжээ. Бавуу-марав гэдэг нь Улаанбаатар гэсэн төвд үг юмсанжээ Ингээд Тавдугаар Богд нэгэн өдөр хүлэг морио бэлтгүүлэн бараа бологсдоо дагуулан морилж Мааньтын хөтлөөс эхлэн Чингэлтэй уулыг энгэрлэн Дамбадаржaa уулын өврөөр Зуун модны даваагаар давж Улиастайн голоор гарч Хужирбулангаар явж Баянзүрхийн араар гараад Туул голыг гатлаад Богд уулын араар Туул голын захаар ороод Буянт-Ухаагаар дамжин Сонголонгоор гол туулан Сонгино хайрханы шилээр эргэж Баруун, Зүүн түрүүгээр ороод Баянхошууны “Нүд” нуураар дайран Мааньтын хөтөл дээр ирж тэг татаж сүм хийд байгуулахаар болжээ. Ийнхүү Гандантэгчилэн хийдийг 1837 оны шар нохой жил барьж байгуулсан гэдэг. Бараа бологсод нь Тавдугаар Богдоос “Танд

их газар морь хүлгээр лагшин чилээрхэхгүй давхиж нар зөв тойрон ирсний учир юусан билээ? хэмээн асуухад: “Миний энэ Их хүрээ ирээдүйд Хот-Мандал босож байшин, гэр орон, хүн ам нь өсөж Их дөрвөн уулынхаа дотор багтажгүй тэлэх учир би газар хэмжиж яваа нь энэ” хэмээн айлдсан гэнэ.

Өөр нэгэн домогт: Их хүрээ бууриа сэлгэж Усан сээрээс нүүдэллэх тухай яригдаж байсан үед гэнэ. Олон шинжээч нар Хүрээ байгуулах газар эрж явсаар Үзэсгэлэнт тэгш тал, уул, ус хосолсон үнэхээр сайхан газар болох Архангай аймгийн нутаг болох “Тоглохын их тал”-д иржээ. Тэд морь малаа амрааж энд Хүрээ байгуулья гэхэд нэгэн өвгөн шинжээч ганцаараа үзье гэж хэлээд өглөөний наран ургахаас эхлэн оройн нар шингэх хүртэл өндөр уулын орой дээр өдөржин сууж гэнэ. Маргааш орой нь сар гарахаас эхлэн үүр цайтал шенөжин уулын оройд хоноод ирэв гэнэ. Нөгөөдөр нь адууны зуун хөх хомоол түүж зуун газар тавиад өдөржин сахиж ажиглаад ирж гэнэ. Нөгөөдрийн маргааш нь салхигүй сайхан өдөр байжээ. Өвгөн шинжээч зуун зул асаан зуун гал түлж өдөржин сахиж суусаар орой ирэхдээ ингэж хэлэв гэнэ.

Хоёр Тамирын бэлчирт  
Хот баримаар сайхан тал байлаа ч  
Хожим хойтохыг бодож  
Хойт хүрээний ёсыг саналаа  
Ургах нарыг шингэтэл  
Уулын оройд суулаа  
Уг нь нарны хишиг буян буусан  
Дүүрэн жаргалтай нутаг байна.  
Зуны нарыг шингэтэл  
Зургаан мичид ортрл суулаа.  
Зундаа сайхан ч  
Өвөлдөө хүйтэн цас их унадаг газар  
байна.

Живэр живэр салхинд  
Зуун хомоол тавьж үзлээ  
Жилийн ихэнхдээ салхи шуургатай  
юм байна.  
Шивээ өвс хөдлөх салхигүй өдөр  
Шинжиж зуун зул асаалаа.  
Халуун зундаа бүгчим

Хайруу цагтаа хүйтэн бололтой  
Алс холын уулыг ажиж суухад  
Ариун буяны өлзийтэй  
Арслан зааны шинжтэй  
Асар сайхан нутаг байлаа ч  
Урд талын уулыг удаан шинжих тусам  
Араг үүрч хүүхдээ хөтөлсөн  
Гүйлгачин бүсгүйн шинжтэй юм байна.

Хүрээг энд байгуулвал алсдаа ядуурах юм байна гэж хэлээд болиулж гэнэ. Шинжээчид тэндээсээ явсаар Хүй Мандал буюу Дамбадаржаагийн хийд байгаа газрыг дайрч явсаар одоогийн Улаанбаатар хотын төв хэсэг Гадаад явдлын Яамны орчим байсан хүн чулууны хөшөөний дэргэд ирэхэд өвгөн шинжээч ихэд олзуурхан бэлэгшэн хадаг дэлгэн ёсолж удтал шинжиж хэд хоносны эцэст ингэж хэлэв гэнэ.


Энэ хүн чулууны хонхорт хүний мөр тасрах ёсгүй, их хөлийн газар байна. Урд уулын хэлбэр нь ембүү мэт, урсгал гол нь хадаг мэт, уул, ус тэгшхэн сайхан хангай байна. Олон барын хodoод хэлбэртэй энэ хөндий өлзийтэй. Хүрээний суурь тавихад маш сайн, хөнөөл хорлол бага, муу хулгай урд ууланд тогтох ёсгүй, муу явдал гаравч сөнөх тавилантай хот болох юм байна. Айх аюул нь ус. Амар төвшний сахиул мэт дөрвөн уулынхаа лус, савдгийг тахиж Дүнжингаравын оройд мөнх зул асааж чадваас айх аюулгүй, амар тайван жаргана гэж айлдаж хүрээний шав босгосон ийм эртний сайхан ёслол шингэсэн нутаг газар болой.



*Xoëp.*

## ДҮҮРГИЙН ГАЗАР ЗҮЙН БАЙРШИЛ, БАЙГАЛЬ, ЦАГ УУР

**Θ**мнийг тэтгэгч-цагаан лавай буюу Дүнжингараавхэмээх Богдхануул нь дэлхийн ууган дархан газрын нэг бөгөөд Монгол туургатныг нэгтгэж эхлэхээс өмнө буюу 1200-аад оны үеэс ард түмний дунд дархлагдан хамгаалж ирсэн 700 гаруй жилийн түүхтэй юм. 1720 оноос Их Хүрээний ойр хавь газар, түүний дотор Богд ууланд ан гэрөө хийхийг хатуу хорилож ирсэн байна. Хан уулын архомдой, Хатан Туулын хөндийд Өргөө буюу Их Хүрээг байгуулсан тэр цагаас Богд хан хэмээн өргөмжлөн нэрлэх болжээ. Үүнээс өмнө нь Хан Хайрхан хэмээн нэрлэж байсан нь түүхийн баримт бичигт үлджээ. Богд хан уулыг Тэнгэр тэтгэсний 44 дүгээр он буюу 1778 онд дархан цаазтай, ариун аглаг уул болгох тухай айлтгал бичгийг Их Хүрээний сайд, жүн ван Юндэндорж гэдэг хүн Манжийн хаанд өргөн барьсан байна. Энэхүү сайд Юндэндорж нь Өндөр гэгээн Занабазарын төрсөн дүү засаг бээл Шижирбаатарын удмын хүн байсан бөгөөд уйгаржин Монгол бичгийн цагаан толгой зохиож байсан тэр үеийн төр, нийгмийн нэрт зүтгэлтэн байжээ. Жүн ван Юндэндорж нь 1837 оны үед Зайсангийн амны доод боргионы эхэнд байгаа өндөр уулын энгэр дээр Богд хааны ундны усыг ариун байлгахын үүднээс “Умаа хум” гэсэн төвд үсгийг цагаан чулуугаар өрж тавьснаас хойш энэ уулыг Умаа хум толгой гэдэг болжээ. Түүнээс хойш 99 жилийн дараа 1936 онд Ардын Хувьсгалын 15 жилийн ойгоор “Умаа хум” үсгийн оронд “Соёмбо”



бүхий Ардын Хувьсгалын 15 жилийн ой мандтугай” гэж бичих болсноор жил бүр уламжлагдаар ирсэн байна.

1779 онд Богд хан уулыг албан ёсоор дархалж хааны зарлиг гарсан бөгөөд Хан Хайрхан гэж нэрлэж байсныг өөрчилж “Богд хан” хэмээн өргөмжилж түүний хоёр ноён оргилыг “Түшээ гүн”, “Цэцээ гүн” цол олгож жил бүр 2000 ширхэг 50 лангийн ембүү цалин сантай болгож эдгээрийг дархалсан тухай зарлигыг Монгол, Манж үсгээр бичсэн гэрэлт хөшөөг босгосон түүхтэй билээ. Цэцээ гүний орой дээр найман талтай, мянган зааны хушуутай, алтан ганжууртай, дэрэвгэр дээвэртэй улаан хайс /ямпий/ бүхий сүм байгуулжээ. Энэхүү сүмийг Их Хүрээний Вангай аймгийн зүгээс байгуулсан бөгөөд Богд Дүнжингаравын сүм хэмээн нэрлэж байсан тухай түүхэнд тэмдэглэгджээ. Уг сүмд Богд Дүнжингаравын эзэн сүлд – Хүнгарьдыг залдаг байсан бөгөөд Шижирбаатарын хөө, хуяг, арваад хүрэл бурхад байсан гэдэг билээ. Тухайн үедээ Богд хан уул, Цэцээ гүн, Түшээ гүний овоог жилд хоёр

удаа тахидал байсан бөгөөд тэр үед бөөгийн шашин зонхицж байсан учир “Улаан тахилга” үйлдэг байжээ. Богд хан уулыг тахихад Халх дөрвөн аймаг, шавь долоон хошуунаас тус бүр наадамд барилдах бөх 200, харваач 100, морь 7, хонь 64, сэрг 5-ийг тус тус гаргахаар зарлиг гаргаж ёсчлон биелүүлж байсан байна. Түүнээс хойш жил бүр хавар, намрын улиралд Богд хан уулыг тахихиадад бууж ирэн Дүнжингаравын дэнжид наадмаа хийдэг байжээ.

Богд хан уулын ноён оргил нь Цэцээ гүн бөгөөд өндөр нь 2268 метр билээ. Дараа нь Түшээ гүн, Зүүн, баруун Ширээтийн оргилууд орно. Газар нутаг, хөрсний хувьд өндөр уулын нугын хөрс, тайгын ширэгт болон цэвдэгт хөрс, ой, хээрийн хар, хүрэн хөрс голлоно. Богд хан уулын дархалсан газрын хэмжээ 40,8 ам дөрвөлжин км, бүх ойн талбай нь 18,0 ам дөрвөлжин км бөгөөд уулын чулуулгын хувьд бүдүүвтэр ширхэгт ухаа цайвар боржин асмалжин, хадан цагаан, хувирмал занар, билүүн занар, элсэн чулуу зэрэг гүний болон хурдас чулууллаг, эрдэс баялагын агууламж бүхий металл ба



Цагаан хаалга

металл бус ашигт малтмалын илрэлтэй юм. Богд хан уул нь хад цохио, асга хонгил ихтэй, гүн ам, хөндий, гуу жалга, горхи булаг, элдэв төрлийн эмийн ургамал, өнгө бүрийн өвс, навч, цэцэг дэлгэрсэн, орчиндоо чийглэг уур амьсгал бүрдүүлсэн үзэсгэлэнт сайхан газар билээ.

Богд хан ууланд 420 гаруй зүйлийн цэцэгт ургамал, 66 зүйлийн хөвд, 100 гаруй зүйлийн эмийн болон ашигт ургамал, 220 гаруй зүйлийн өвслөг ургамал ургадаг бөгөөд хар мод, хуш, шинэс, гацуур, нарс, хус, улиас, улиангар, тэс, хайлс бүхий холимог ойтой, арц, сургар, балгана, тавилгана, яргай, чаргай, бүйлс, гандгаар, монос, зэрэг 20 гаруй зүйлийн бут сөөгтэй, хад, гүзээлзгэнэ, бөлжиргөнө, тэхийн шээг, алирс, мойл гэх мэтийн жимс, жимсгэнэ ургадаг. Мөн 45 зүйлийн хөхтөн, 116 зүйлийн жигүүртэн, 5 зүйл хоёр нутагтан байдаг бөгөөд буга, бор гөрөөс, хүдэр, гахай, булга, хэрэм, жирх, үен, солонго, үнэг, чоно, хярс, мануул, чандага, туулай, тарвага, зурам зэрэг ан амьтан шивээлсэн уул юм.

Богд хан уул нь “Хангарьд” савдагтай бөгөөд “Түшээ гүн” болон “Цэцээ гүн” хоёр оргил нь тус тусдаа овоотой, төр, засаг, шашны тахилгат овоод учир эдгээр овоог тахихад заавал төр, засгийн зарлиг гардаг учиртай билээ.

“Зайсан толгойн овоо” нь 1925 он хүртэл Богдын шавийн харьятууд тахиж байжээ. Ардын хувьсалаас өмнө Богдын шавь нар гэж тусгай давхаргынхан байжээ. Эдгээр айл өрхүүдийг Их шавийнхан ч гэдэг байв. Тэд нар тусдаа захирагатай, дагаж мөрддөг журам, цаазтай байжээ. Богдын шавийн отгийн айл өрхийг “Зайсан” цолтой хүн ахалдаг байсан байна. Шавь нар жил бүр Богд эзэндээ бараалхан мөргөж идээ, ундаа, олз омгийнхоо дээжээ өргөдөг, олон арван морь, тэмээ, хүн хүч хэрэглэн алба хүргэж ирдэг байсан байна. Албаны энэхүү их ачаа хөсгийг отгийн зайнсангууд удирдаж хавар нь ирээд намар нь буцдаг байжээ. Алс холоос ирсэн Богдын шавь нар адуу, тэмээ малтайгаа Богд уулын ар талын нэг аманд бууж морь, тэмээ, малаа өвөр талын нэг ам руу давуулан маллаж овоогоо тахиж



Нисэхийн цагаан хаалга

ёс төрөө гүйцэтгэдэг байсан учир энэхүү хоёр амьг “Ар Зайсан”, “Өвөр Зайсан” гэж нэрлэн овоо бүхий толгойг нь “Зайсан толгой” хэмээн нэрлэх болсон гэдэг. Овоо байсан газар нь одоо “Зөвлөлтийн дайчдын хөшөө” байгуулсан байна.

Чандмана толгойн овоо нь “Хийморь хайрхан” дээр байдаг ба эрт дээр үеэс бөхчүүд ихээр шүтэж байсан эр хүний хийморь сэргээдэг овоо юм. Түүний доохно байх овоог “Бүсгүйн овоо” гэх бөгөөд эмэгтэйчүүд эртнээс ихэд шүтэж иржээ.

“Адисын давааны овоо” /Одоо ард түмний дунд “Айдасын даваа” гэж ташааран нэрлэгдэх болжээ/ нь дээр үеийн хүрээний хил, хязгаарын зааг буюу хилийн овоо юм. Одоо түүнийг хурдан морины уяачид болон бүх нийтээрээ хүндлэн шүтдэг болжээ.

“Сонгино хайрхан” Уул нь “Хөх өвгөн” савдагтай юм. Энэ хайрхан нь таван хэсэг уулаас бүрдэх ба уул бүр нь овоотой. Гол овоо нь “Дарцагт хангай” уулын оройд буй.

Түүний доохно бэлээс археологич Г.Наваан нарын эрдэмтэд XIII зууны

язгууртан баатар хүний алтан бүс олсон юм. Мөн 1190 онд Жамух, Ван хаан нар Чингис хаантай байлдах үед Чингис хааны хянах байр Сонгино хайрхан уулын өндөрлөгт байрлаж байсан, энэ уулын урд талд Ван хааны ордон байрлаж байсан нь нотлогдсон юм.

Иймээс “Сонгино хайрхан” уул нь Баатар, дайчин эрсийн шутээн уул юм.



*Гурав.*

## ДҮҮРГИЙН ТӨР, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

# 1921

оны Ардын хувьсгалын ялалтын нэг жилийн ойг 1922 оны 7 дугаар сарын 30-наас 8 дугаар сарын 1-ний өдрүүдэд Яармагын дэнжид хийсэн байна. Энэ үед Нийслэл хотын бүхий л хэргийг Дотоод Явдлын Яам эрхлэн явуулж байжээ. Нийслэл хотын ажил, амьдралаас урган гарч байгаа шинэ шинэ зорилтуудыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Нийслэлийн өөрийн гэсэн засаг захиргаа байгуулахыг зүй ёсоор шаардаж байлаа.

Иймд 1923 оны 10 дугаар сард Нийслэл хотын захиргаа байгуулах, хотын захиргааны дурмийг боловчуулах тусгай комиссыг байгуулах тухай МАХН-ын Төв Хороо, Засгийн Газрын шийдвэр гарснаар “Монгол Улсын хотын түр захиргааны дүрэм”-ийг 1924 оны 3 дугаар сарын 7-ний өдөр Засгийн Газрын хурлаар хэлэлцэн баталжээ. 1924 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр Нийслэлийн түр захиргааг байгуулан 27 хороотой байхаар зохион байгуулж эдгээр хорооны харьяат оршин суугчдын хурлаас дүрмийн ёсоор 45 хүнийг Нийслэл хотын түр хурлын гишүүдэд сонгож байсан байна. Үүнээс хойш удалгүй нэг сарын дараа хороодын тоог цөөлж 13 хороо болгожээ.



Үүнд: Тэр үеийн Сэцэн вангийн хороо, Жонон вангийн хорооны айлуудыг Өндгөн сургийн айлуудтай нэгтгэн Дунд голын хороог Наймдугаар хороо болгож даргаар нь бэйс Ишгомбо гэдэг хүнийг сонгосон байна.

Наймдугаар хороо нь одоогийн Замын цагдаагийн газрын ар, хуучин тавдугаар халуун усны орчмоос Дунд голын хойт талыг даган Вагон засвар, Дулааны шугам сүлжээний газрын орчим хүртэл хиллэж урд талаараа Богд уул, Туул голын сав хөндийгээр Сонгинын амралт хүртэл хиллэж байжээ.

Улсын Ахдугаар их хурлын 1924 оны 10дугаар сарын 29-ний өдрийн 14 дүгээр хуралдаанаар Нийслэл хотыг БНМАУ-ын Нийслэл хот болохыг давтан хуульчилж хотын нэрийг “Улаанбаатар” хэмээн нэрлэсэн байна. 1926 он гэхэд хотод шинээр 2 хороо нэмэгдэж 15 хороотой болсон байсныг Хотын Төлөөлөгчдийн Ахдугаар хуралдааны шийдвэрээр 9 хороо болгон цеелснээр Наймдугаар хороо нь Есдүгээр хороотой нийлж Дөрөвдүгээр хороо болсон байна. 1928 оны 2 дугаар сараас Улаанбаатар хотын хороодын тоог дахин цомхотгож 6 хороо, 133 корин болгожээ.

Энэ уед Дөрөвдүгээр хороо нь бусад хороотой нийлж Тавдугаар хороо болсон бололтой. Тавдугаар хороонд энэ уед хотын жинхэнэ харьяат нарын өрх 198, түр захирагдах өрх 901, хүн ам 2544 тус тус аж төрж байжээ. Гадаадын харьяат бүгд 209 иргэн байсны 105 нь орос, 99 нь хятад, 5 нь герман иргэн байсан байна. Тавдугаар хороонд нийт 3065 толгой мал байсны дотор тэмээ 52, адuu 308, үхэр 775, хонь, ямаа 1929 тус тус байжээ.

1930-1934 онд Улаанбаатар хотын баруун ёмиед заход, Цагаан сүмийн хойдох хөндийд Аж Үйлдвэрийн Комбинатыг ЗХУ-ын тусlamжтайгаар барьж байгуулж эхэлсэн бөгөөд 1934 оны 3 дугаар сарын 26-ний өдөр Гутлын фабрик, Цахилгаан станц, Булигаарын завод, Арье дээлийн үйлдвэр, Цэмбэний фабрик гэсэн 5 үйлдвэртэйгээр ашиглалтанд орсон байна.

Аж Үйлдвэрийн Комбинат бол Улаанбаатар хот төдийгүй улс нийтийн ихээхэн ач холбогдолтой, тухайн үеийн

барилга, байгуулалтын том ажил болсон бөгөөд 1936 онд Аж Үйлдвэрийн Комбинатыг түшиглэн шинээр хороо зохион байгуулж Долдугаар хороо гэж нэрлэсэн байна.

1948 онд явагдсан орон нутгийн засаг захиргааны сонгуулиар Улаанбаатар хотын захиргааг “Хотын хөдөлмөрчдийн бага хурлын Тэргүүлэгчдийн газар” гэж нэрлэх болсон байна. Энэ уед Долдугаар хороо нь Зургаадугаар хороо болж 12 хоринтойгоор ажиллаж байсан байна. Хорооны хэмжээгээр 4051 өрхтэй, 19,0 мянга гаруй хүн амтай байсан ба хорин бүр 200-500 өрхтэй, 1500-2500 хүн амтай байжээ.

Сонгуулийн шинэ системээр 1952 оны 10 дугаар сард явагдсан орон нутгийн сонгуулиар Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн бага хурлын тэргүүлэгчдийн газар гэж байсныг “Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатуудын хурал” гэж нэрлэх болсон бөгөөд энэ уед Улаанбаатар хотод Чингэлтэй, Баруун сэлбэ, Чойбалсан, Их Сургуулийн, Сүхбаатарын, Ажилчин, Уурхайчдын, Хоршооллын, Амгаланбаатарын, Толгойтын, Улиастайин, Төмөр замын, Зүүн сэлбэ гэсэн 13 хороотой болсон байна.

1958 оны 7 дугаар сард хороодын тоог 10 болгон цөөлж хорооны захиргааг байгуулсан ба дарга, нарийн бичгийн дарга, бичээч, зарлага, аж ахуй, цэвэрлэгч гэсэн орон тоотой болсон байна. Энэ уед Ажилчин хороо захиргаа нь 12 хоринтой, 5000 өрхтэй, 24,0 мянган хүн амтай, 74 үйлдвэр, аж ахуй, албан байгууллагатай, 2762 толгой малтай байсан байна.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1965 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 79 дүгээр зарлигаар Улаанбаатар хотын засаг захиргааны зохион байгуулалтанд өөрчлөлт оруулж 10 хороо захиргаа байсныг татан буулгаж Сүхбаатар, Октябрь, Найрамдал, Ажилчин, Налайх гэсэн 5 районаыг байгуулж Районы Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргаа гэж нэрлэжээ.

1977 онд Нийслэл хотын хэмжээнд байсан 100 гаруй ОСГ-ны хороодыг цөөрүүлж 98 хороотой болгож хороодын

дарга нарыг орон тооны болгон ажиллуулсан нь засаг захиргааны анхан шатны нэгж болсон хороодыг зохион байгуулалтын хувьд бэхжүүлээд зогсоогүй байнгын удирдлагатай болгож төрийн ажил үүргийг тогтвортой гүйцэтгэх бололцоогоор хангасан байна. Энэ уед Ажилчны районы хэмжээнд ОСГ-ны 20 хороо байсныг 16 хороо болгон зохион байгуулсан юм.

Монгол Улсын Шинэ Үндсэн хуулийг Улсын Их Хурлаар 1992 оны 1 дүгээр сарын 13-ний өдөр баталснаар Монгол Улсын Нийслэл, аймаг, дүүрэг, сум нь хуулиар тусгайлсан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор болон хөгжих хууль, эрх зүйн үндэстэй болсон юм.

Энэхүү шинэ Үндсэн хуулийн дагуу Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль батлагдаж 1992 оны 9 дүгээр сард Нийслэл Улаанбаатар хотын районуудын засаг захиргааны зохион байгуулалт өөрчлөгдөж шинэ бүтэц, зохион байгуулалт бүхий Дүүргүүдийг байгуулсан байна. Ийнхүү Ажилчны район нь үндсэндээ 2 дүүрэг болсон бөгөөд Хан-Уул дүүрэг нь 12 хороотой, Туул дүүрэг нь 2 хороотой тус тус байгуулагдсан байна.

1992 оны 9 дүгээр сарын 9-нөөс 9 дүгээр сарын 14-ний өдрүүдэд Хан-Уул дүүргийн хороодуудад Иргэдийн Нийтийн Хурлууд хийгдэж Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 60 төлөөлөгчийг шинээр сонгож улмаар хороодын Засаг дарга нарыг сонгох сонгууль явагдсан байна.

Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн анхдугаар хуралдаан 1992 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр хуралдаж Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн даргаар А.Цанжидыг, нарийн бичгийн даргаар И.Лхамсүрэнг, тэргүүлэгчдээр А.Цанжид, И.Лхамсүрэн, Д.Батгомбо, Н.Мягмар, Ц.Энхээ, Н.Цэдэв, М.Шийдорж нарыг сонгож баталжээ. Мөн дүүргийн Засаг даргаар Т.Билэгтийн нэрийг дэвшүүлж Нийслэлийн Засаг даргын захирамжаар томилон ажиллуулсан юм.

1995 оны 2 дугаар сард Нийслэлийн Гачуурт, Жаргалант, Туул дүүргийг татаан буулгаж Туул дүүргийг Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо болгон Тосгоны зохион байгуулалтаар ажиллуулах болсон байна.

### ДҮҮРГИЙН ТӨР ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫГ УДИРДАЖ БАЙСАН ШИЛДЭГ СЭХЭЭТНҮҮД

1. Ж.Нансал 1965-1976 оны 5 дугаар сар хүртэл,
2. Ж.Дашдаваа 1976 оны 7 дугаар сараас 1983 оны 5 дугаар сар хүртэл,
3. Б.Мянганбаяр 1983 оны 5 дугаар сараас 1985 онд,
4. Б.Соном 1985-1991 онд,
5. Ц.Батнасан 1992-2000 онд,
6. Д.Загджав 2000 оноос ажиллаж байна.

Тайлбар: 1992 оноос эхлэн МАХН-ын ажлыг Дүүргийн Засаг дарга нар хавран гүйцэтгэдэг болсон юм.

#### Б. Ажилчны районы АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны дарга нар:

1. Б.Цэвэгдорж 1965-1972 онд,
2. Г.Цэдэвдорж 1972-1975 онд,
3. Л.Ойдовсамбуу 1975-1992 онд,
4. Т.Билэгт 1992-1995 онд,
5. Ц.Батнасан 1995-2000 онд,
6. Д.Загджав 2000 оноос ажиллаж байна.

#### Г. Хан-Уул дүүргийн Засаг дарга нар:

1. А.Цанжид 1992-1994 онд /орон тооны бус байсан/
2. Б.Ёндонжамц 1994-1996 онд /орон тооны бус байсан/
3. И.Лхамсүрэн 1996-2000 онд /орон тооны болсон/
4. Д.Совдоо 2000 оноос ажиллаж байна.

Тайлбар: Дүүргийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга нь 1992-1996 он хүртэл орон тооны бус ажиллаж байсан бөгөөд 1996 оноос эхлэн ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга нь нарийн бичгийн даргын ажлыг давхар гүйцэтгэж байсан болно.

Д. Ажилчны районы АДХ-ын Гүйцэтгэх  
Захиргааны орлогч дарга нар:

1. Ч.Цэрэнпил 1990-1991 онд,
2. Ц.Батнасан 1991-1992 онд,

Е. Хан-Уул дүүргийн Засаг даргын орлогч нар:

1. Ц.Батнасан 1992-1995 онд,  
2000-2004 онд,
2. Б.Батхуяг 1995-2000 онд
3. Х.Баттулга 2004 оноос  
ажиллаж байна.

Ё. Ажилчны районы АДХ-ын Гүйцэтгэх  
Захиргааны хариуцлагатай нарийн бичгийн  
дарга нар:

1. Ч.Цэндмаа 1965-1967 онд,
2. Д.Долгорсүрэн 1967-1975 онд,
3. Т.Даваа 1975-1978 онд,
4. М.Буянбат 1978-1984 онд,
5. Г.Маналжав 1984-1987 онд,
6. Д.Хулганаа 1987-1989 онд,
7. П.Цэнджав 1989-1990 онд,

Ж. Хан-Уул дүүргийн Засаг Даргын Тамгын  
Газрын дарга нар:

1. С.Сониу 1992-1993 онд,
2. С.Бямбадорж 1993-2001 онд,
3. Г.Элдэвсүрэн 2001 оноос  
ажиллаж байна.

## ДҮҮРГИЙН ДАРГА НАР



Б.Чөвөгдорж  
1965-1972 онд дүүргийн  
даргаар ажиллаж байв.



Г.Цэдэвдорж  
1972-1975 онд дүүргийн  
даргаар ажиллаж байв.



Л.Оидовсамбуу  
1975-1992 онд дүүргийн  
даргаар ажиллаж байв.



Т.Билягт  
1992-1995 онд дүүргийн  
засаг даргаар ажиллаж  
байв.



Ц.Батнасан  
1995-2000 онд дүүргийн  
засаг даргаар ажиллаж  
байв.



Д.Загджав  
2000 оноос дүүргийн  
засаг даргаар ажиллаж  
байна.

## ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ДАРГААР АЖИЛЛАЖ БАЙСАН ХҮМҮҮС



А.Данжид  
1992-1994 онд орон тооны бус ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргаар ажиллах байв.



Б.Эндөнжамц  
1994-1996 онд орон тооны бус ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргаар ажиллах байв.




И.Лхамсирэн  
1996-2000 онд ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргаар ажиллах байв.



Д.Совдоо  
2000 оноос ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргаар ажиллах байна.

ДҮҮРГИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



*Дөрөв.*

## АЖИЛЧНЫ РАЙОНЫ АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРАЛ, ДЕПУТАТУУД

**О**рон нутгийн Хурал, захиргааны байгууллага болох Ажилчны районы Ардын депутататуудын Хурал болно Гүйцэтгэх захиргаа хоёр нь 1990 он хүртэл нэгдмэл нэг байгууллага байсан билээ. Энэ үед Районы Гүйцэтгэх захиргаа нь өөрийн бодлого шийдвэрээ Хуралд тулгах байдлаар батлуулж биелэгдэж болох зүйлээ шийдвэрлүүлэя Сонгуульт байгууллага- Ардын Депутатуудын Хурлын нэр хүнд, гүйцэтгэх үүргийг ихээхэн бууруулж байсан байна.

Энэ гажуудлыг арилгах зорилгоор 1989 онд БНМАУ-ын үндсэн хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулж АДХ-ыг Ардын Хурал болгож орон нутгийн иргэдийн хурлаар Ардын Хурлын тэргүүлэгчдийг сонгодог болсон байна. Ардын Хурлын Тэргүүлэгчдийн дарга болон орлогч дарга нь орон тооны бус, харин Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нь орон тооны байдлаар ажиллаж эхэлсэн байна. Ардын Хурлын тэргүүлэгчдийн Хурлын тасралтгүй ажиллагааг хангаж бүх шатны Ардын Хурлын сонгуулийг бэлтгэн явуулах, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэнд хяналт тавьж хэрэгжүүлэх, депутатууд болон байнгын комиссуудын ажлыг зохицуулах, туслах, зөвлөө чиглэл өгөх, чуулганыг зарлаж бэлтгэлийг хангах, хууль, хяналт, нам, олон нийтийн байгууллага, хөдөлмерчидтэй байнгын холбоотой ажиллах, нутаг дэвсгэртээ нийгэм, эдийн засгийн бодлого, хууль ёсыг сахин биелүүлэх ажлыг тус тус зохион байгуулж ажилладаг байв.

Ийнхүү Ардын Хурлын байгууллага нь Гүйцэтгэх захиргаанаас тусгаарлаж өөрийн бие даасан байр сууриа олж эхэлсэн нь хурлын байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, депутат, байнгын комиссын ажлыг чиглүүлж туслах, Хурлаас гаргасан

шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, үр дүнг тооцож ажиллах боломжийг бурдүүлсэн юм. Хурлын байгууллагын гол аппарат нь түүний тэргүүлэгчид, байнгын комисс байдал бөгөөд эдгээрийн нэр хүнд, үүрэг хариуцлагыг дээшлүүлэхэд голлон анхаарч бие даасан, шуурхай ажиллагааг сайжруулах нь хэзээ ямагт үндсэн зорилт байсаар ирсэн байна.

Ажилчны районы АДХ нь 1981 оны үед дараахь байнгын комисс, хороодтой ажиллаж байсан байна. Үүнд:

1. Төсөв, төлөвлөгөө, санхүүгийн байнгын комисс /дарга нь ХААДС-ийн орлогч захирал П.Сэргчиномпил/
2. Аж уйлдвэр, барилга, хөдөө аж ахуйн байнгын комисс /дарга нь Арье ширний үйлдвэрийн нэгдлийн дарга Б.Шагдар/
3. Худалдаа, үйлчилгээ, тээвэр холбооны байнгын комисс /дарга нь Авто засварын заводыг дарга Д. Тэгшибуянт/
4. Хөдөлмөрийн нөөц, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн асуудал эрхэлсэн байнгын хороо /дарга нь техник туслалцааны үйлдвэрийн барилга трестийн намын хорооны нарийн бичгийн дарга Г.Чойжамц/
5. Ардын боловсрол, соёл, эрүүлийг хамгаалах байнгын хороо /дарга нь Д.Сүхбаатарын нэрэмжит Намын дээд сургуулийн орлогч захирал Б.Даш-Ёндон/
6. Хот тохижуулалт, байгаль хамгаалах байнгын хороо /дарга нь Барилгын үйлдвэрлэл, эрдэм шинжилгээний институтын захирал Н.Тогтох/
7. Хууль ёс, нийгмийн хэв журам сахиулах байнгын хороо /дарга нь Ажилчны районы Намын хорооны намын комиссын дарга Б.Цэн-Ойдов/ нар тус тус ажиллаж байсан байна.



Ажилчын район наийгүүлэгчдээны 20 жилийн ойн баярт оролцсон хөдөлжиний төлөөлөгчид. (1985 он)

*Tav.*

## ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ТӨЛӨӨЛӨГЧИД

1990 оны 6 дугаар сард орон нутгийн Ардын Хурлын сонгууль болж олон намын төлөөлөгч оролцсон анхны Хурал байгуулагдав. Энэ үеэс Ардын Хурлын Тэргүүлэгчдийн даргад Гүйцэтгэх захиргааны даргын үүргийг хавсруулах тухай БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол гарч Хурал, захиргааны ажил, үүрэг дахин нэг хүнд шилжиж байсан юм.

Тэр үеийн Хурал нь төрийн эрх барих статустай байсан болохоор тухайн орон нутгийн удирдлаганаа сонгож баталдаг, аль ч шатны удирдлагад тодорхой асуудлаар асуулга тавьдаг, биелэлтийг нь сонсож дүгнэлт өгдөг хяналтын томоохон үүрэгтэй байв. Шилжилтийн эхэн үе буюу 1990-1991 онд Хурлын үйл ажиллагаа нилээд идэвхжиж нутаг дэвсгэрийнхээ бүхий л асуудлыг идэвхтэй шийдвэрлэж зарим талаар туйлширч, туршилагагүйтэж эхэлсэн байна. Нэг намын байр суурь алдагднаар орон нутгийн бүх боловсон хүчнийг Хурал мэдэж улмаар халах, солих, огцуруулах, томилох ажил түргэн түргэн хийгдэх болов. Негээ талаар төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг задарч аймаг, нийслэл, дүүрэг, сумаас мах, сүү, ноос, ноолуур, үр тариа, төмс, хүнсний ногоо зэрэг улсад нийлүүлдэг бүтээгдэхүүнээ тушаахаа болж үнийг нэмэгдүүлэх, зах зээлээ өөрдөө олох сонирхолд хөтлөгдөн тэр, Засгийн газраас орон нутгаа удирдан жолоодох, зохицуулах үүрэг хүндэрч эхэлсэн юм. Иймээс Хуралд олгосон эрх мэдэл, чиг үүргээ эргэж хянах шаардлага бий болж улмаар Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг боловсруулах явцад

тусгалаа олж Төрийн эрх барих статустай Хурал нь Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болж өөрчлөгдсөн юм.

Ийнхүү 1992 оноос нутгийн өөрөө удирдах ёс Монгол улсын үндсэн хуулиар баталгаажиж орон нутгуудад Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Иргэдийн Нийтийн Хурлууд бий болсон байна.

Шинэ Үндсэн хуулинд зааснаар: "Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага буюу Дүүргийн ИТХ нь нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна" гэсэн заалтыг тус дүүргийн хурлын байгууллага удирдлага болгон ажиллаж байна.

Дүүргийн ИТХ-ын байгууллагын бүтэц, зохион байгуулалт нь 1992-1996 онд орон тооны бус Хурлын тэргүүлэгчдийн даргатай, орон тооны нарийн бичгийн даргатайгаар үйл ажиллагаагаа явуулж ирсэн юм. 1996 оноос Дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга, нарийн бичгийн дарга- хурлын ажилтан гэсэн 2 орон тоотой болж үйл ажиллагаа нь бэхжэсэн байна. 2004 оноос дүүргийн ИТХ нь Тэргүүлэгчдийн дарга, нарийн бичгийн дарга, хурлын ажилтан, хуулийн ажилтан, жолооч гэсэн 5 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

1965-2005 оны хооронд Ажилчны районы АДХ-ын Гүйцэтгэх захиргааны даргаар болон Хан Уул дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргаар ажиллаж байсан хумүүс:



*Зургаа.*

## ДҮҮРГИЙН ТӨР ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУД

**M**анай улс орны амьдралд гарсан түүхэн хөгжлийн өөрчлөлт, шинэчлэлийн явцад төр, захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа улам боловсронгуй болсоор ирсэн билээ.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үе буюу 1965-1990 онуудын хооронд төр, захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа нь нутаг дэвсгэрийн үйлдвэр, аж ахуй, соёл, боловсрол, эрүүл мэндийн байгууллагуудыг нэг намын үзэл суртал, бодлого шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн удирдаж улс ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилтуудыг ханган биелүүлэх ажилд байгууллага, хөдөлмөрчдийг өргөнөөр татан оролцуулах явдал байсан билээ.

Зах зээлийн эдийн засгийн харилцааны үе буюу 1990 оннос хойш хугацаанд Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжих хууль, эрх зүйн үндэстэй болсон юм. Монгол улсын нутаг дэвсгэр, засаг захиргаа нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт хуваагдаж аймаг нь суманд, сум нь багт, Нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороодод тус тус хуваагдаж үйл ажиллагаагаа явуулахыг Үндсэн хуулиар баталгаажуулж өгснөөр хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор болон хөгжих үндэс суурь бий болсон билээ.



Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газрын төв байр

1992 онд баталсан Монгол улсын шинэ Үндсэн хуулийн дагуу дүүргийн Засаг дарга нь өөрийн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт Монгол улсын хууль, тогтоомж, Засгийн газар, Нийслэлийн засаг даргын бодлого шийдвэрийг хэрэгжүүлж гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцан ажиллах болсон юм. Дүүргийн Засаг даргын ажлын алба нь түүний Тамгын газар юм. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газрын тогтоол болон Нийслэлийн Засаг даргын захирамжаар тус тус тогтоодог.

Нийслэлийн Ажилчны районы АДХ-ын Гүйцэтгэх захиргааны болон Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадын үүсэл, замналын талаар товч танилцуулай. Үүнд :

Монгол улсын Нийслэл-Улаанбаатар хотод үйлдвэр, аж ахуй, соёл, боловсрол, эрүүл мэнд, үйлчилгээний салбарууд шинээр бий болж тэдгээрийн харьяа байгууллагууд олширч хүн ам ессенеөр засаг захиргааны зохион байгуулалтыг өргөтгөж Нийслэл хотын нутаг дэвсгэрийг райончлах нь зүйтэй гэж үзээд БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1965 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 79 дүгээр зарлигаар Нийслэлийн 10 хороо захиргаа байсныг татан буулгаж шинээр Сүхбаатар, Октябрь, Найрамдал, Ажилчин, Налайх гэсэн 5 районыг байгуулж эдгээр районуудын засаг захиргаа болох АДХ-ын Гүйцэтгэх захиргаадыг байгуулсан юм.

Ажилчны районы АДХ-ын 7 дахь удаагийн анхдугаар чуулганыг 1965 оны 6 дугаар сарын 29-ний өдөр хийж 71 депутатуудыг сонгож районы захиргааны 9 гишүүнийг томилж районы АДХ-ын Гүйцэтгэх захиргааг Санхүүгийн ба Гэгээрлийн гэсэн хоёр хэлтэстэй, 18 орон тоотойгоор байгуулсан байна. Тус районы АДХ-ын Гүйцэтгэх захиргааны даргаар Б. Цэвэлдоржийг, хариуцлагатай нарийн бичгийн даргаар өмнө нь Ажилчин хороо захиргааны даргаар ажиллаж байсан Ч.Цэндмааг тус тус томилон ажиллуулсан байна. Ажилчны районы АДХ-ын Гүйцэтгэх

захиргааны даргын 1965 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 2 дугаар захирамжаар дараах хүмүүсийг ажилд томилон ажиллуулсан байна. Үүнд:

1. Баянгийн Балжирыг Санхүүгийн хэлтсийн даргаар,
2. Сэнгийн Самданг Гэгээрлийн хэлтсийн даргаар,
3. Дэндэвийн Чулуунбаатарыг засаг захиргааны ажил хариуцсан зааварлагчаар,
4. Бармаагийн Дамдингомбыг өргөдөл гомдол, шилжилтийн ажил хариуцсан зааварлагчаар,
5. Жигжавын Нямжавыг хяналт шалгалтын ажил хариуцсан зааварлагчаар,
6. Сайнбуянгийн Дашэзвэгийг гэгээрлийн хэлтсийн нягтлан бодогчоор,
7. Сандуйн Чулууныг төсвийн мэргэжилтэн бөгөөд ерөнхий нягтлан бодогчоор,
8. Гомбожавын Гаажавыг эхчүүдийн тэтгэвэр, тусламж хариуцсан байцаагчаар,
9. Сосорын Ламжавыг аж ахуйн комендант бөгөөд мөнгөний няраваар,
10. Лхамсүрэнгийн Хишигтийг даргын нарийн бичгийн дарга бөгөөд бичиг хэргийн эрхлэгчээр,
11. Цагааны Должинсүрэнг бичээчээр,
12. Самдангийн Хорлоог цэвэрлэгчээр,
13. Донсонгийн Чойжамцыг хөнгөн тэрэгний жолоочоор,
14. Лхамсүрэнгийн Цэвэлдоржийг цэргийн төлөөлөгчээр,
15. Балжмаагийн Найданг бичиг хүргэгчээр,
16. Бэхийн Банзайг орлогын байцаагчаар тус тус томилж байжээ.

1973 онд энэхүү конторынхoo хойт талд 12 өрөө бухий өргөтгөлийн хэсгийг аж ахуйн аргаар барьж ашиглалтанд оруулсан ба 1985 онд дахин өргөтгөл хийснээр 40 өрөөтэй болж хөдөлмерчдийн эрэлт хүсэлт хүлээн авах байр, депутатын танхим, лекцийн ба хурлын заал, цайны газар, хувцас өлгүүр, жижуурийн өрөө зэргийг байгуулж бүрэн тохижуулсан байна. 1965 оны эцэст тус район нь 41800 хүн амтай, 9000 өрхтэй, 1316 толгой малтай, 18 хороотой, жилийн тесөв нь 3,6 сая төгрөгтэйгээр үйл ажиллагаа явуулж байсан юм.

*Долоо.*

## ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ХОРООД

**Т**ус дүүргийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны үндсэн бодлого нь хөрш зэргэлдээ орнуудтай бүх талын түншлэлийн болон хамтын ажиллагааг бэхжүүлж төр, захиргаа, бизнес, хөрөнгө оруулалтын чиглэлээр гадаад харилцааны таатай орчин бүрдүүлэх уламжлалд тулгуурласан харилцан ашигтай, үр бүтээлтэй, нээлттэй идэвхтэй үйл ажиллагааг явуулахад оршиж байна.

Тус дүүргийн гадаад харилцаа нь 2000 оноос эрчимтэй хөгжиж БНСУ-ын

Сеүл хотын Гуанжин дүүрэг, БНХАУ-ын ОМӨЗ орны Эрээн хот, ОХУ-ын Эрхүү хот, Буриад улсын Улаан Үүд хот зэрэг хот, дүүргүүдтэй хамтын ажиллагаа тогтоож төрийн захиргаа, боловсрол, эрүүл мэнд, хот тохижилт, хөрөнгө оруулалт, спортын чиглэлээр үр ашигтай хамтран ажиллаж байна.

Тус дүүргийн нутаг дэвсгэрт АНУ, Англи, ОХУ, Герман, Омнөт Солонгос, Хятад улсын хөрөнгө оруулалттай 200 гаруй үйлдвэр, компаниуд үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд Дэлхийн зөн, Жайка, Адра,



Хорооны дарга наар /1990 он/

Зүйн гаралас: Ц.Дорж, Б.Тэрбиш, М.Шийдорж, Л.Ойдовсамбуу, Ч.Балдан, Данзандорж, Б.Вуянтогтох наар

Их Британий хүүхдийг ивээх сан зэрэг 10 гаруй олон улсын болон хүмүүнлэгийн байгууллагууд ажиллаж боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээний чиглэлээр хөрөнгө оруулалт, тусlamж дэмжлэг үзүүлж байна.

БНСУ-ын Сеул хотын Гуанжин дүүрэг нь тус дүүргийн төр, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж албан ажлын хэрэгцээнд зориулан 2001 онд хоёр суудлын автомашин бэлэглэсэн бөгөөд дүүргийн Спортын Ордон барихад зориулж 40 мянган долларын хандив өгсөн нь том хувь нэмэр болсон билээ. Мөн Гуанжин дүүргийн Күй -2 дугаар хороо нь тус дүүргийн 12 ба 13 дугаар хороотой хамтын ажиллагааны гэрээ байгуулан “Шинэ тосгон” нэrtэй төсөл хэрэгжүүлж ажилласнаар дээрх хоёр хороо нь “Хороо хөгжүүлэх сан” байгуулж нийт 16,0 сая төгрөгийн фондтойгоор үйл ажиллагаагаа явуулж одоогийн байдлаар тус сангаас 120 гаруй иргэд, жижиг бизнес эрхлэгчид нийт 14,0 сая төгрөгийн зээл авч үйлдвэрлэл,

үйлчилгээний ажил явуулсан нь аж ахуйгаа өргөжүүлэх, орлогоо ёсгехэд зохих үр дүнгээ өгсөн байна.

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотын зүгээс тус дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын сургалтанд зориулж 2003 онд 65 компьютер, 2005 онд 50 компьютерийг тус тус олгосон бөгөөд эдгээр компьютерүүдийг 60, 75 дугаар сургуульд суурилуулан “Компьютер-мэдээллийн танхим” байгуулан ашиглаж байна. Эрээн хотоос тус дүүргийн тохижилтонд зориулж хог хаягдал зөөж тээвэрлэх зориулалттай дугуйтай тэргэнцэр 50 ширхэгийг өгсөний зэрэгцээ таримал мод, цэцгийн суулгац, гудамжны гэрэлтүүлэг зэргийг тусlamж болгосон нь дүүргийн тохижилт, соёлжилтонд ихээхэн хувь нэмэр боллоо.

1977 онд Нийслэл хотын хэмжээнд байсан 100 гаруй ОСГ-ны хороодыг цеерүүлж 98 хороотой байхаар зохион байгуулж хороодын дарга нарыг орон тооны болгосон нь хөдөлмөрчин иргэдийн дунд төрийн засаг захиргааны байнгын ажиллагаатай анхан



Хороодын засаг дарга нар (1998 он)

Өвөр эгнээнд зүн гаралт: Т.Болд, О.Буянаа, Д.Цэгмид, Д.Долгор, Л.Цэцэгээ, Б.Жаргалдулам, С.Сандагдорж  
Арын эгнээнд: Г.Жанцан, Л.Лхагвасүрэн, Б.Гэрэл, П.Батхүчээ, Д.Эрдэнэцогт, Ц.Алтанөрэл нар

шатны нэгж ажиллах түүхэн нөхцлийг хангаж өгсөн чухал арга хэмжээ болжээ.

Энэ үед Ажилчны районд ОСГ-ны 20 хороо байсныг 16 хороо болгож зохион байгуулсан байна. Үүнд:

1. Дүүргийн 120 мянгатын бүх орон сууцнуудын байруудыг харьялсан 1 ба 2 дугаар хороо,
2. Дүүргийн 19 дүгээр хороолол болон Нэхмэлийн байруудыг харьялсан 3 ба 4 дүгээр хороо,
3. Төв засмал замын урд талын цагаан байрууд, гэр хэсгийг харьялсан 5 дугаар хороо,
4. Замын хойт талын Эрчим хүчний ажилчдын байрууд, гэр хэсгийг харьялсан 6 дугаар хороо,
5. Яармагын 1 дүгээр буудлын замын урд тал болон хойт талын гэр хэсгүүдийг харьялсан 8 ба 19 дүгээр хороо гэж байсныг вэгтгэж 7 дугаар хороо,
6. Яармагын 2 дугаар буудлын замын хойт

талын гэр хэсгийг харьялсан 8 дугаар хороо,

7. Яармагын 3 дугаар буудлын замын хойт талын гэр хэсгийг харьялсан 9 дүгээр хороо,
8. Яармагын автобусны эцсийн буудлын орчмын гэр хэсгийг харьялсан 10 дугаар хороо,
9. 1974 онд тэр үеийн 10 дугаар хороо-/одоогийн 7 дугаар хороо/-ноос тасарч байгуулагдсан Ажилчны районы 20 дугаар хороо нь Яармагын эцсийн буудлын хойт талын гэр хэсгийг харьялсан 11 дүгээр хороо,
10. Нисэхийн автобусны эцсийн буудлын зүүн хэсгийг харьялсан 12 дугаар хороо,
11. Нисэх орчмын ороя сууц, гэр хэсгийг харьялсан 15 дугаар хороо, /Энэ хороо нь 1974 онд тэр үеийн 10 дугаар хорооноос тасарч 20 дугаар хороо болж байсан байна/



Хороодын дотроос 2003 оны ажлаараа шалгарсан 7, 8, 14-р хорооны хамт олон Өөвр эзэнэнд зүн гарас: О.Цэнгэл, Т.Наранцэг, Л.Хишигтогтох, Н.Дорждулам, Г.Цагвадорж Арын эзэнэнд: М.Лхагвасүрэн, С.Сарантуяа, Э.Оюунномин, Ч.Алтанцэг, Б.Баярмаа

12. Биокомбинат шинээр байгуулагдаж тэнд шилжин суурьших хүн ам олширсноос Биокомбинатын орон сууцны байрууд болон гэр хэсгийг харьяалсан 13 дугаар хороо,
13. Зайсангийн орон сууцны байрууд болон гэр хэсгийг харьяалсан 14 дүгээр хороо,
14. Бөхег, Түргэний орчимд 1964 онд Улсын анхны Шувууны фабрик шинээр байгуулагдснаар Ажилчны районы ОСГ-ны 16 дугаар хороо ажиллаж байгаад 1983 онд Туул хороо болгон Улаанбаатар хотын захиргаанд харьяалуулав.
15. 1984 онд Бугын Сангийн аж ахуй байгуулагдсан тул түүний ажилчид болон нутгийн иргэдийг харьяалсан засаг захиргааны Өлзийт дэх хэсгийг 1991-2000 онд ажиллуулж байв.

Монгол Улсын Шинэ Үндсэн Хууль батлагдаж Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг шинэ зохион байгуулалтанд оруулах болсонтой холбогдуулан Монгол Улсын Их Хурлын 1992 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 23 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн Газрын 1992 оны 5 дугаар Хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын Тэргүүлэгчдийн 1992 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор Дүүргүүдийн хороог шинэчлэн байгуулсан юм. Энэхүү тогтоолын дагуу Хан-Уул дүүргийн 16 хороог 12 хороо болгожээ.

Ийнхүү 1977 онд зохион байгуулагдсан 16 хороог доорхи байдлаар 12 хороо болгосон юм. Үүнд :

1. Хуучин 1, 2 дугаар хороодыг нэгтгэж 1 дүгээр хороо,
2. Хуучин 3, 4 дүгээр хороодыг нэгтгэж 2 дугаар хороо,
3. Хуучин 5, 6 дугаар хороодыг нэгтгэж 3 дугаар хороо,
4. Яармагын хуучин 7 дугаар хороог 4 дүгээр хороо,
5. Яармагын хуучин 8 дугаар хороог 5 дугаар хороо,
6. Яармагын хуучин 9 дүгээр хороог 6 дугаар хороо,
7. Яармагын хуучин 10 дугаар хороог 7 дугаар хороо,
8. Яармагын хуучин 11 дүгээр хороог 8 дугаар хороо,
9. Нисэхийн хуучин 12 дугаар хороог 9 дүгээр хороо,
10. Нисэхийн хуучин 15 дугаар хороо, Өлзийтийн 16 дугаар хэсгийг нэгтгэж 10 дугаар хороо,
11. Зайсангийн хуучин 14 дүгээр хороог 11 дүгээр хороо,
12. Биокомбинатын хуучин 13 дугаар хороог 12 дугаар хороо болгон тус тус зохион байгуулсан юм.

Харин Шувууны фабрикийн хуучин Туул хороог Туул дүүрэг болгож 2 хороотойгоор зохион байгуулан ажиллуулсан билээ.

Монгол Улсын Засгийн Газрын 1995 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 23 дугаар тогтоолоор Туул дүүргийг татан буултаж Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо болгон Тосгоны зохион байгуулалтаар ажиллуулсан юм.



## ХАН-ҮҮЛ ДҮҮРГИЙН ТҮҮХ



Хан-Үүл дүүрэгийн элсээ дараа зогийн балгызлач наар дүүрэг балгызлачны 35 жилийн ойн хүчинчлэгийн ажиллагаанд оролцсон өдэрээс 2000 он.  
Өөзор энэхүү зорилтад: С.Цэвэлмаа, М.Байлалыжав, Ч.Долгор, Ч.Баярын, Ч.Наранчаг, Т.Наранчаг, Л.Нэнээ, Ч.Хандаасын, Б.Улаанчирхэг, Ч.Монгайхан,  
Н.Поражаев, Д.Чижээнийн; Г.Жанцан, Б.Бод, Ц.Алтанчирхэг, Н.Байдамьяд, Г.Шинжүүч, О.Баяндаа, Д.Баясанхүү, П.Баттолол, Ц.Ганчимээр, Д.Эрдэнэцэвт

Архи зөвлөх: С.Сайнбатдорж, М.Лхагваасүрэн, В.Сулжана,

*Арван хоёр.*

## ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ҮЙЛДВЭР АЖ АХУЙН БАЙГУУЛЛАГУУД

### 1. БОГД ХААНЫ МУЗЕЙ

Дарнатаын хувилгааны 23 дахь дүр болох VIII Богд Жавзандамба Агаанлавсанчойжиниам нь 1869 оны шороон мөгий жил Баруун Түвд нутгийн Лхас хотод Далайламын Санхүүч, чинээлэг түшмэл Гончигцэрэнгийн хүү болон төржээ. 1871 онд Богд Жавзандамбыг VIII дахь дүрээр тодруулан 1873 оны хавар эцэг, эх, ах дүү нарын хамт түвдээс залж авчруулах ажлыг Манж Чин Улсын эзэн хааны зарлиг ёсоор гүйцэтгэсэн бөгөөд 1874 оны 10 дугаар сард Их хүрээнд угтаж авч Халх дерөв, шавь таван аймгийн ихэс дээдэс, сүсэгтэн олон мөргөлчид цуглаж

Богд гэгээний сэнтийд суулгажээ.

Ийнхүү VIII Богд Жавзандамба нь 1874 онд Монголын шашины тэргүүнээр залагдаж ирсэн бөгөөд 1911 оны эрх чөлөөний хувьсгалаар Богд хаант олноо өргөгдсөн Монгол Улсын шашин төрийг хослон баригч, наран гэрэлт түмэн наст эзэн гэгээн хаанаар өргөмжлөгдэн 1921 он хүртэл суусан байна.

1921 оны Ардын хувьсгал ялах үед Богд Жавзандамбыг хэмжээт эрхт хаанаар өргөмжлөн 1924 он хүртэл залж байгаад Богд хаан 1924 онд 55 настайдаа өвчний улмаас таалал төгссөн байна.



Ардын Намын Төв Хороо, Засгийн Газрын 1926 оны 4-р сарын 1-ний өдрийн тогтоолоор Улсын музейг үүсгэн тохижуулах товчоог байгуулж VIII Богд Жавзандамбын эзэмшилд байсан түүх, соёл, урлагын зүйл, бурхан тахил, угсаатны эд, өлгийн зүйл, төрөл бурийн амьтны чихмэл дүрс зэргийг музейд шилжүүлэн улмаар Богдын өвгийн ордонд музейг өргөмжлөн байрлуулах шийдвэр гаргасан байна.

1954 онд МАНХ-ын Төв хороо, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 464/46 дугаар тогтоолоор Улсын төв музей байгуулах шийдвэр гаргасны дагуу тус музей нь улсын төв музейн харьяа музей болж ажиллаж байгаад 1961 оноос биеэ даан тусгаарлан Богд хааны ордон музей болжээ.

Зуны мөргөлийн сүм, Өвлийн ордон гэсэн хоёр үндсэн хэсэгтэй бөгөөд тус музейд XVII- XX зууны эхэн үеийн Монголын хаант төр, шашины түүх, урлаг соёлын давтагдашгүй хосгүй үнэт дурсгалууд, нэрт үрчүүдүн бүтээсэн цутгамал бурхад, тортон зургууд, Богд хаан, Дондогдуулам хотын ёмсөж эдэлж байсан дээл хувцас, эдлэл хэрэглэлүүд сан хөмрөгт нь бий.

Богд хааны ордон музей нь Монгол улсын төрийн онцгой хамгаалтанд багтдаг түүх соёлын дахин давтагдашгүй дурсгал цогцолбор юм.

## 2. УДИРДЛАГЫН АКАДЕМИ.

1923 онд хуралдсан МАНХ-ын 2 дугаар их хуралын шийдвэрийн дагуу 1924 онд Номын түр сургуулийг байгуулсан бөгөөд сургалтынхаа үйл ажиллагааг МАН-ын түр хорооны байранд 1924 оны 4-р сарын 5-нд эхэлсэн түүхтэй бөгөөд анхны захирал нь Ц. Дашибадарт томилогдсон байна. 1924 онд нутгийн Захиргааны шинэчлэлийг түргэгтэх, Улсын анхдугаар их хурлын бэлтгэл ажлыг хаагуулахад туслалцуулах зорилгоор 18-30 наасны нийт 60 залуусыг нийслэл хүрээнээс зарлан дуудсан. “Номын түр сургууль” нэртэй нэг сарын сургалт семинар хийгээд орон нутагт томилан ажиллуулжээ. Энэхүү түр сургууль нь 1925 онд Намын Төв Сургууль, 1933 онд Нам ба Улсын төв сургууль 1941 онд Намын шинэ хүчиний дээд сургууль, 1954 онд МАНХ-ын Төв хорооны дэргэдэх намын дээд сургууль, 1990 оноос Ардын их хурлын дэргэдэх Улсын дээд сургууль, 1992 оноос Улсын бага Хурлын дэргэдэх Төр нийгэм судлалын академи, 1994 оноос Монгол Улсын Засгийн газрын дэргэдэх Төрийн захиргаа, Удирдлагын хөгжлийн институт, 1999 оноос Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Удирдлагын академи болон зохион байгуулагдсан юм.

Өнгөрсөн 80 гаруй жилийн хугацаанд



Нэамийн дээд сургууль нь Нам улсын газрын бүрэн шатны удирдах ажилтан 20-иад мянган боловсон хүчин бэлтгэгдсэн байна. Тус академи нь Төрийн Удирдлагын, Бизнесийн удирдлагын, Нийгмийн удирдлагын сургуулиуд, Удирдлагын ухааны хүрээлэн, удирдлагын коллеж гэсэн 5 бүрэлдэхүүн сургуультай, мэргэжлийн 8 тэнхимтэй, сургалтын алба, Санхүү, аж ахуйн алба, компьютерийн лобаратори, хэвлэх тасаг номын сан бүхий бүтэцтэй ажиллаж байна. Академийн захирлын дэргэдэх эрдмийн зөвлөл, Захиргааны зөвлөл, Сургалтын арга зүйн зөвлөл тус тус ажилладаг. Академийн багшлах бүрэлдэхүүнд 90 орчим багш ажиллаж байгаагийн дотор докторын зэрэгтэй 28 багш, докторын зэргийн сургалтанд 20 гаруй багш хамрагдаж байна.

### 3. АПУ ХК

Манай улсын анхны үйлдвэрүүдийн нэг Архи пивоны завод нь анх 1924 онд 7 ажилчнитайгаар байгуулагдаж өдөрт 50 литр хятад хар архи үйлдвэрлэн гаргаж байв. Энэхүү Архины заводыг түшиглэн 1924 оны 5 дугаар сард “Архины онц хэргийг эрхлэх газар” -ыг байгуулсан нь одоогийн АПУ ХК-ийн үндэс суурь болжээ. 1957-1958 оны үед тус завод нь өдөрт 7-8000 пиво, 3-5000 литр архи үйлдвэрлэн гаргаж, жилдээ 23 сая турван зуун мянган төгрөгийн бүтээгдэхүүнийг гаргаж байжээ.

Тус заводыг 1957 онд өргөтгэж суулийн үеийн тоног төхөөрөмжөөр тоноглож мэргэжилтэй ажилчдаар хангасан ба тэр үедээ 150 гаруй ажиллагсадтай байв. 2001 онд “АПУ” ХК нь өөрийн үйлдвэрээ Австри, Герман, Итали улсын орчин үеийн тоног төхөөрөмжөөр иж бүрэн шинэчилсэн юм. Жилд 20 сая литр пиво үйлдвэрлэх хүчин чадалтай пивоны үйлдвэрийг ашиглалтанд оруулсан байна. Одоо “АПУ” ХК нь 6,0-8,0 сая литр архи дарс, коктейль үйлдвэрлэх хүчин чадалтай болжээ. “АПУ” ХК нь өөрийн бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулах сүлжээтэй болж хот, хөдөөд 140 гаруй бөөний төв, гэрээт борлуулагчийг ажиллуулж байна. “АПУ” ХК нь 2003 оны 6 дугаар сараас ус, ундааны үйлдвэрийг Европын холбооны эрүүл ахуйн шаардлага хангасан түвшинд үйлдвэрлэх үйлдвэр шинээр ашиглалтанд оруулсан байна.

### 4. МИАТ КОМПАНИ

Улаанбаатар хотын консульян дэнжийн жижиг аэродром дээр 1925 оны 5-р сарын 25-ны өдөр Ю-13 тээврийн онгоц газардснаар Монгол улсын нисэх хүчний түүх эхэлжээ. Анхны нисэх отрядыг Ю-13 маркийн тээврийн 3 онгоцтойгоор байгуулж даргаар нь Д.Ламжавыг томилсон байна. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1946 оны 3-р сарын 7-ний өдрийн 16 дугаар тогтоолоор байлдааны цагийн нисэх дивизийг тайван цагийн орон тоонд шилжүүлэн Засгийн газрын ба иргэний шууданг аймаг орон



нутагт түргэн хүргэх, хүн эмнэлэгийн яаралтай тусламж үзүүлэх зорилгоор Иргэний нисэх отрядыг байгуулсан байна.

Энэхүү отряд нь “Супер” онгоц 5, хоёр хүний суудалтай “ПО-2” онгоц нэгтгэйгээр байгуулагдажээ. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1956 оны 6-р сарын 1-ний өдрийн 272 дугаар тогтоолоор Ховд, Чойбалсан аймгийн чиглэлд Ан-2 онгоцоор иргэний агаарын тээврийн нислэг хийлгэхээр шийдвэрлэснээр анхны зорчигч шуудан тээврийн байнгын нислэг эхэлсэн түүхтэй юм. 1958 онд БНМАУ-ын агаарын зайн тухай хууль гарч 1961 онд Буянт-Ухаагийн нисэх онгоцны буудлыг өргөтгэж шинэ Аэро вокзал, цардмал талбай байгуулан орчин үеийн том онгоц хүлээн авах, удирдах холбоо, навигацийн болон шенийн гэрэл, суултын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна. 1972 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор Батлан Хамгаалах Яамны харьцанд Иргэний агаарын тээврийн удирдах газрыг байгуулжээ. 1992 оны 4 дүгээр сард Улсын бага хурлаас “Агаарын зайд нислэг үйлдэх тухай” хууль батлагдан 1993 оны 6 дугаар сард Иргэний Агаарын Тээврийн Удирдах Газар байгуулагдсан юм. 1992 оноос “Хангарьд”, “Тас”, “Дуут”, “МИАТ” зэрэг авиа компаниуд биеэ даасан нислэг хийн олон түмэнд үйлчилж байна. Монгол улсын нутаг дэвсгэр дэх агаарын зайд Ази-Европ, Хойд Америк-Ази тивүүдийг холбосон агаарын шинэ замууд нээгдснээр

агаарын хөдөлгөөн нэмэгдэж байгаатай уялдуулан ADS/C ажиглалтын системийг агаарын шугамд ашиглаж байна. Агаарын хөлгийн парк шинэчлэлийн хүрээнд АНУ-ын “БОИНГ” компаниас “БОИНГ-737” агаарын хөлгийг 2002 оны 7 дугаар сараас түрээсээр авч олон улсын нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байна.



#### БУЯНТ-УХАА ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДАЛ

Монгол улсад иргэний агаарын үйлчилгээ 1956 оноос эхэлж 1961 онд Буянт-Ухаад хатуу хучилт бүхий зурвастай нисэх буудал барьж ашиглалтанд оруулснаар нисэх буудлын тухайн замнал эхэлсэн байна. 1986 онд ЗХУ-ын тусламжтайгаар цагт 500 зорчигч үйлчлэх хүчин чадалтай нисэх буудлын шинэ барилга ашиглалтанд орсноор олон улсын жишгийн нисэх буудлын үйлчилгээ бий болжээ. Буянт-Ухаа ОУНБ-ын өргөтгөлийн ажлыг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 1994-1997 онд хийж гүйцэтгэсэн билээ.



### 5. УБ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХК


Улаанбаатар хотыг нэгдсэн сүлжээгээр цахилгаанаар хангах зорилгоор 1931 онд 500 кв чадалтай цахилгаан станц 40 км урт цахилгаан дамжуулах шугам, 33 транспортерын дэд станцын хамт барьж байгуулан энэхүү цахилгаан шугам сүлжээний ашиглалтыг хариуцах байгууллагыг Дунд голын “Чийдэнгийн хороо” нэртэйгээр 1932 оны 2-р сарын 27-ны өдөр зохион байгуулан ажиллуулснаар одоогийн УБЦТС компанийн үндэс суурь тавигджээ. 2001 онд УИХ-аас “Эрчим Хүчний тухай” хууль батлагдан мөрдөж эхэлснээр УБ хотын цахилгаан шугам сүлжээний газрыг 2001 оны 8-р сараас “УБ Цахилгаан Түгээх Сүлжээ” ХК болгон өөрчлөн зохион байгуулсан байна. Тус компани нь 18.9 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөтэй 11.3 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй өөрийн мэдлийн нийт хувьцааны 20 хувийн СЭЗЯам, 39 хувийг өөрийн өмчийн хороо, 41 хувийг ДБЯам тус тус эзэмшдэг. Тус компани нь жилд дунджаар 1 тэрбум гаруй сая киловатт цахилгаан эрчим хүчийг өөрийн эзэмшлийн шугам сүлжээгээр дамжуулан хэрэглэгчдэд хүргэдэг. УБЦТС ХК нь нийслэл хотын б дүүрэг, Төв аймгийн 16 сумын хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүч түгээх, хангах үйлчилгээ үзүүлж байна. Компанийн хэмжээнд 6600 орчим ААНБ,

140 гаруй айл өрхийн 860 гаруй мянган хүн амд жилд 30 гаруй тэрбум төгрөгийн цахилгаан эрчим хүч түгээн борлуулдаг. Тус компани 12 алба, 3 хэсэг, 8 салбар, 1192 ажиллагадтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

### 6. БУЛИГААР ХК

Аж үйлдвэрийн комбинат нь 1936 онданх ашиглалтанд ороход Булигаарын заваод нь үндсэн бүрэлдэхүүнд нь багтаж ашиглалтанд орсноор одоогийн Булигаар ХК-ийн үндэс тавигджээ. Булигаарын завод ашиглалтанд орохдоо шохой, идээлэх, гүйцэтгэх гэсэн 3 үндсэн цехтэй жилдээ 50000 ширхэг бодын шир боловсруулах хүчин чадалтай жилдээ 100 мянган төгрөгийг ажил гүйцэтгэж 90 орчим ажилчидтайгаар үйл ажиллагаагаа эхэлсэн байна.

Булигаарын заводаас том ширийн үйлдвэр, улны ширний үйлдвэр, шетретийн үйлдвэр, шевроний үйлдвэр бие дааж гарсан байна. 1976 онд БНСЧУ-ын техник эдийн засаг, мэргэжилтний тусламжтайгаар хром-юфтын шинэ үйлдвэр, 1976 онд улны ширний шинэ цехийг тус тус ашиглалтанд оруулжээ. 1998 онд Итали улсын техник технологиор тус компанийн тоног төхөөрөмжийг иж бүрнээр шинэчилсэн байна. Тус компани нь 18 үйлдвэрийн цех, тасагтай 350 гаруй ажиллагадтай, 124



үйлдвэрлэлийн машинтай, жилдээ 215.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 306.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

#### 7. "БИОКОМПИНАТ" УЛСЫН ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

1936 онд ЗХУ-ын техник мэргэжилтэний тусlamжтайгаар Сонгино дахь Биокомбинатыг барих ажил эхэлж 1938 онд ашиглалтанд оруулснаар боом цусан халдварт паратифит вакцин үйлдвэрлэх үндсэн 7 тасагтай, улсын шалган шинжлэх лаборатори, бактерийн тэжээл бэлтгэх цех жижиг байр зэрэг салбартай орчин үеийн био үйлдвэртэй болсон юм. 1973 онд БНУАУ-ын тусlamжтайгаар Сонгино дахь Биокомбинатыг шинэчлэн өргөтгэн ашиглалтанд оруулснаар жилдээ 70-аад нэр төрлийн 20 сая төгрөгийн био бэлдмэл, эм тарилга үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр ажиллаж эхэлсэн байна.

#### 8. АТАР ӨРГӨӨ ХК

1941 онд УБ хотын хүнсний трестийн харьцанд талхан заводыг анх байгуулсан нь одоогийн Атар Өргөө компанийн үндэс суурь болжээ. Тус компанийн 380 гаруй ажиллагсадтай ба эх орны улаан буудайн гурилаар 80 гаруй нэр төрлийн хүнсний болон талхан бүтээгдэхүүнийг эрүүл

ахуйн шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэж байна. Атар Өргөө компани нь хүнс үйлдвэрлэгч тэргүүний үйлдвэр-ХҮнсний манлай үйлдвэр, Нийслэлийн шилдэг ААН, Монгол улсын Шилдэг ААН, Тор-10, Нийслэлийн хэрэглэгчдийн найдвартай түвш зэрэг өргөмжлел цомоор шагнагдсан байна.

#### 9. "ОРГИЛ" РАШААН СУВИЛАЛ

1933-1934 оны үед аж үйлдвэрийн комбинатыг барьж байх үед 90 гаруй метрийн гүнд өрөмдөж гаргасан худгаас рашаан ус илрүүлсэн нь одоогийн Рашиан сувиллын үндэсний төвийг байгуулах үндэс суурь болсон байна. Энэхүү рашаан нь нүүрсхүчилийн хийтэй, хоол боловсруулах эрхтэн болон зүрх судасны архаг өвчиг анагаахад хэрэглэж болох дүгнэлт гарсан байна. 1934 оноос тус рашааныг ашиглаж байснаар жилдээ 500 гаруй хүн эмчилгээ сувиллалд хамрагдаж байлаа. 1952 онд 50 ортой сувиллын газар байгуулан ажиллуулж байгаад 1956 оноос дахин өргөтгэж 1958 онд жилдээ 150 ортой рашаан-сувиллын газрыг ашиглалтанд оруулснаар нэг ээлжинд рашаанд 12 хүн, шавар эмчилгээнд 16 хүн зэрэг үйлчлүүлэх 2 үндсэн тасагтай, цахилгаан болон усан эмчилгээ, шилмүүст рашаан, эмчилгээний биеийн тамир, иллэг,



зүү төнүүр, ўйл оношын кабинет зэрэг сувилгаа шинжилгээний хүчин чадалтай байнгын ажиллагаатай сувиллын газар болсон юм. 1974 оны өвөл 300 ортой “Оргил” рашаан сувиллын газрыг 1987 онд тус сувиллын дэргэд рашаан, шавар эмчилгээний иж бүрэн цогцолбор тус тус ашиглалтанд оруулжээ. Тус сувиллын газрыг түшиглэн 1991 оны сүүлчээс рашаан, сувиллын газруудыг мэргэжлийн чиглэлээр зохицуулах Рашаан-сувиллын үндэсний төв байгуулагдан ажиллаж байна.

#### 10. АВТОБУС-1 КОМПАНИ

Тус компани нь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1954 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 77-р тогтоолоор Тээврийн Яамны харьяанд Автобус-Такси-Моторын бааз нэртэйгээр анх байгуулагджээ. Тэр үед тус бааз нь 10-20 хүний суудалтай 28 автобустай өдөрт 4450хүнд үйлчилдэг байжээ. 1957 онд Автобус ба Такси гэсэн биеэ даасан 2 бааз болон өөрчлөгдсөн бөгөөд 1982 онд Автобус бааз нь 1 ба 2 дугаар паркийн зохион байгуулалтанд орж ажиллаж байгаад 1990 оноос автобусны биеэ даасан хоёр компани болжээ. 1995-1997 онд Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусlamжаар Nissan маркийн автобус 60 ширхэг Хино маркийн автобус 40 ширхэг нийт 100 автобусыг сэлбэг болон засвар үйлчилгээ, гүйцэтгэх станцын

барилга, төхөөрөмжийн хамт ашиглалтанд оруулсан байна.

Дээрх тусlamжийн үр ашгийг нарийн тооцохын тулд 1997 оны сүүлчээс Автобус-1 компанийг Япон улсын тусlamжийн хүрээнд дагнан ажиллуулахаар шийдвэрлэжээ. Одоо тус компани нь 6500 ажиллагсадтай 100 автобустайгаар Нийслэл хотын зорчигч тээврийн 40 гаруй хувийг дангаараа гүйцэтгэж 9 чиглэлд үйлчилгээнд гарч өдөрт 6,7 сая төгрөгийн орлоготойгоор ўйл ажиллагаа явуулж байна. Тус компаниас хөдөлмөрийн баатар 2, гавьяат тээвэрчин 3, Сүхбаатарын одонт 3, хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт 9, алтан гадас одонт 40, хөдөлмөрийн хундэт медальтай 59, улсын аварга тээвэрчин 60 гаруй, хот дүүргийн аварга 40 гаруй, осолгүй манлай жолооч, онц тээвэрчин 180 гаруй тус тус тэрсен байна.

#### 11. ХААИС

1958 онд ХААИС-ийг МУИС-аас тусгаарлан байгуулж малын их эмч, агрономич, зоо техникч, ойн инженер, ХАА-н машины инженер, эдийн засагч, тэжээлийн мэргэжилтэн бэлтгэн гаргадаг байв. 1957-1958 оны хичээлийн жилд тус сургуульд 700 гаруй оюутан суралцаж байв. 1984 оны үед тус сургууль дээд боловсролтой мэргэжилтнийг 30 гаруй мэргэжлээр




сургаж БНВАУ, БНАСАУ зэрэг социалист орнуудын оюутныг хүлээн авч суралцуулж байв. Тус сургуульд суралцагч оюутаны тоо хичээлийн жилийн эхэнд 1970 онд 700 гаруй, 1980 онд 900 гаруй, 1984 онд 2000 гаруй, 2005 онд 7000 гаруй болж өсчээ. ХАА-н олон мянган мэргэжилтнүүдийг сургаж бэлтгэхэд профессор Ц.Жамынжав, Б.Яринпэл, Б.Үүхээ, М.Төмөржав, Д.Гончиг зэрэг олон эрдэмтэн багш нар тодорхой хувь нэмэр оруулсан билээ. ХАА-н салбарт дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэдэг эрдмийн уурхай болсон тус сургууль нь материаллаг нөхцөл, багшилах боловсон хүчний хувьд ихээхэн өргөжин хөгжсөн юм. 1990 онд ХААИС, 1993 онд ХАА-н бүх чиглэлийн сургалт, эрдэм шинжилгээний судалгаануудын нэгтгэсэн МУ-ын ХААИС болсон байна. Одоо тус сургууль нь бакалавр, магистер, докторын сургалтанд 26 мэргэжлээр 7000 гаруй оюутан 600 шахам магистрант, 50 гаруй докторант 500 гаруй багш ажилтан ажиллаж байна. ХААИС нь бүрэлдэхүүндээ агробиологи, байгалийн ухаан, инженер, МАА-н менежмент, мал эмнэлэг, био технологи, эдийн засаг бизнес, экологи-технологийн хөгжлийн гэсэн биеэ даасан сургуулиудтай бөгөөд Дархан-уул, Ховд, Орхон аймагт салбар сургуулиуд тус тус ажиллаж байна. Мөн Дархан, Дорнод, Ховд, Архангай,

Улаангом, Батсүмбэр, Сүхбаатар,Өмнөговь зэрэг аймгуудад эрдэм шинжилгээний хүрээлэн станц, сургалтын лабораториуд, сургалт судалгаа, үйлдвэрлэлийн төвүүд ажилладаг. Тус сургууль нь мал эмнэлэг, эрдэм шинжилгээний хүрээлэн, МАА-н эрдэм шинжилгээний хүрээлэн, ургамал газар-тариалангийн сургалт эрдэм шинжилгээний хүрээлэн, ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдтэй хамтран ажилладаг.

Тус сургууль нь эрдэм шинжилгээний 30 лаборатори, 200 мянган номтой номын сан, урлаг спортын зал, оюутны 4 дотуур байртай 11 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөтэй үйл ажиллагаа явуулж байна. Нийт оюутны 15 гаруй хувь нь дотуур байранд амьдардаг.

## 12. ШУВУУН ФАБРИК БУЮУ БӨХӨГ ХК

1964 онд УБ хотын Сонгинод 30000 ширхэг өндөглөгч тахиатай 5,0 сая идэшний өндөг, 700 центр тахианы мах гаргах хүчин чадалтай анхны Шувуун фабрикийг барьж ашиглалтанд оруулсан байна. 1977 онд МАХН-ын төв хороо, Сайд нарын Зөвлөлийн тогтоол гарч Сонгино дахь Шувуун фабрикийг 100.0 мянган өндөглөгчтэй болгох зорилтыг хэрэгжүүлсэн бөгөөд тус фабрикийг өргөтгөн хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлсэн нь шувууны аж ахуйг



эрчимтэй хөгжүүлэх бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд ойртуулах үр ашгийг нэмэгдүүлэх томоохон арга хэмжээ болжээ. 1978 оны байдлаар Улсын хэмжээгээр уржүүлж байгаа шувууны 84.0 хувийг Сонгино дахь шувуун фабрикт уржүүлж байсан байна. Энэ үед жилд дунджаар 28.7 мянган ондоглогчоос 4.555.0 ширхэг ондог авч хүнсний хэрэгцээнд нийлүүлж байжээ. Энэ нь нэг ондоглогч жилдээ 182 ширхэг ондог гаргаж байсан байна.

### 13. ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ-3 ХК

Дулааны цахилгаан станц-3 ХК нь 1968 оны 12 сарын 10-ны өдрийн ЗХУ-ын техникийн тусламжтайгаар анхны зуух баригдаж ашиглалтанд орсноор үндэс суурь нь тавигджээ. Тус станцын анхны трубин 1973 оны 12 дугаар сарын 1-ны өдөр ашиглалтанд орсноор цахилгаан дулааны эрчим хүчийг түгээж эхэлжээ. Тус станц нь нүүрс хэрэглэдэг 2 станцаас бүрдэх бөгөөд дунд даралтын станц 48 мегаватт, онд даралтын станц 100 мегаватт суурилагдсан хүчин чадалтай юм. Дунд даралтын станц нь 1975 онд 6 зуух, 4 трубинтэйгээр, онд даралтын зуух нь 1983 онд 7 зуух, 4 трубинтэй тус тус ашиглалтанд оржээ. Тус компани нь 6 киловольтын хүчдэлийн түвшинтэй цахилгаан эрчим хүчийг

боловсруулж агаарын шугамаар эрчим хүчний нэгдсэн системтэй холбогдон өөрийн орны цахилгаан эрчим хүчний хэрэглээний 17 хувь, УБ хотын дулааны эрчим хүчний хэрэглээний 32 хувийг хангадаг. Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “Говь”, “Эрэл”, “АПУ”, “Атар Өргөө”, “УБ хивс”, “АОСС”, “Бетон Арматур”, “Монфреш” ХХК зэрэг 60 гаруй компанийн үйлдвэр, салбаруудыг үйлдвэрийн хэрэгцээний уураар хангадаг. Тус станц нь 972 ажиллагсадтай бөгөөд 61 хувь нь 35 хүртэлх насны залуучууд, 45 хувь нь дээд тусгай, дунд боловсролтой ажилтнууд эзэлдэг. Тус станц нь улсын онцгой объект учраас ажиллагдаас мэргэжлийн ондөр ур чадвар, хатуужил, сурч мэдэхийн төлөө уйагүй зүтгэл хөдөлмөрийг шаарддаг тул тэдгээрийн ажиллах амрах нөхцлийг хангахад онцгой анхаарал тавьдаг.

Ажиллагсадад зориулсан 500 хүний суудалтай соёлын төв, 200 хүн зэрэг хооллох цайны газар, спортын заал танхимаар үйлчилдэг.

### 14. ТӨВИЙН БУСИЙН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ СУЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХК

Манай орны эрчим хүчний үйлдвэрийг нэгдсэн системтэй хөгжүүлэх, төвийн бусийг



бүхэлд нь хамарсан эрчим хүчний систем бий болгох зорилт үйл ажиллагаа 1960-аад оноос эхлэн тавигдаж хэрэгжсэн байна. 1967 онд УБ хотын дулааны 2 цахилгаан станц нь Дархан хотын дулааны цахилгаан станцтай 110 киловаттын шугамаар холбогдоор төвийн эрчим хүчний систем үүсэх үндэс суурь тавигджээ.

1968 онд төвийн эрчим хүчний системийг байгуулснаар төвийн бүсэд цахилгаан дулааны эрчим хүчийг үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагаа нэгдсэн нэг системээр хийгдэх болсон юм. 1990-2000 оны хооронд ТЭСХ хүрээгээ тэлж өргөжин хөгжсөөр төвийн эрчим хүчний систем суурилагдсан нийлбэр хүчин чадал буюу УБ хотын дулааны 2,3, 4-р цахилгаан станцууд, Дархан, Эрдэнэтийн ДЦС-уудын нийлбэр хүчин чадал нь 774 мегаваттад хүрсэн байна. 2001 онд УИХ-аас Эрчим хүчний тухай хуулийг баталснаар Эрчим Хүчин салбарт бүтцийн өөрчлөлтийг хийж ЗГ-ын 2001 оны 7-р сарын 9-ны өдрийн 164-р тогтоолоор “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ” компани зохион байгуулагдсан байна.

Бүсийн Цахилгаан дамжуулах сүлжээ нь УБ, Дархан, Эрдэнэт, Чойр, Архангай,Өвөрхангай болон Сэлэнгэ, Төв, Дорнговь,

Дундговь, Хэнтий аймгуудын нутаг дэвсгэрийг хамарсан систем бүхий алслагдсан хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангаж байна. Тус компани нь 220 киловаттын 1705км, 110 киловаттын 2759 км-ын өндөр хүчдэлийн шугам, 110-220 киловаттын 54 дэд станцтайгаар ажиллаж байна.

ОХУ-ын Буриадын эрчим хүчний системтэй 220 киловаттын цахилгаан дамжуулах агаарын шугамаар зэрэгцээ ажилладаг ба шаардлагатай нехцэлд цахилгаан эрчим хүчийг импортлодог юм. Тус компани нь бүтэц зохион байгуулалтын хувьд Улаанбаатарт төвтэй Дархан-Сэлэнгэ, Эрдэнэт-Хархорин, Багануур-Чойрын гэсэн 3 салбартай нийт 699 ажиллагсадтай юм.

### 15. УБ ХИВС ХК

Монголын машинт хивсний анхын үйлдвэр болох Улаанбатар хивсний үйлдвэрийг 1962 оны 5-р сарын 06-ны өдөр ашиглалтанд оруулжээ. Тус үйлдвэр нь нэг зэлжинд жилдээ 175 хавтгай дервэлжин метр хивс үйлдвэрлэх хүчин чадалтайгаар баригдсан бөгөөд 1978 онд үйлдвэрийн хүчин чадлаа бүрэн ашиглаж эхэлснээр 2 зэлжинд жилдээ 450-500 хавтгай дервэлжин метр хивс үйлдвэрлэдэг болжээ.



УБ хивсний үйлдвэр нь 1992 онд хувьчлагдаж “УБ хивс” ХК болон үйл ажиллагаагаа явуулж байна. Тус компанийн бүтээгдэхүүний үндсэн түүхий эд нь цэвэр монгол хонины инос бөгөөд нэхэлтийн технологи нь 3 хөндлөн утасны бэхэлгээтэй жаккарт хээтэй давхарлан нэхэх технологитой юм. Тус компанийн бүтээгдэхүүн-Алтанбулаг, Алтай хивс хивсэнцэрүүд нь дотоодын зах зээлд төдийгүй гадаадын зах зээлд өргөн эрэлттэй байдаг юм. Олон улсын үзэсгэлэн яармагаас олон удаа шилдэг бүтээгдэхүүний шагналыг хүртэж байсан байна.

#### 16. “ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ”

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1980 оны 9 дүгээр сарын 12 ны 298 дугаар тогтоолоор Ноолуур боловсруулах комбинатын эх үндэс тавигджээ. Тус комбинат нь 1980-аад оны сүүлчээр жилд 50 гаруй сая америк долларын ноолууран бүтээгдэхүүн экспортлож байсан нь тухайн үеийн Монгол улсын чөлөөт валютын жилийн орлогын 70 хувийг дангаараа оруулж байв. Тус комбинат нь 1980 оны 10 дугаар сарын 1-нээс үйл ажиллагаагаа

эхэлж комбинатын захиргаа байгуулагдсан бөгөөд 1981 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр тус комбинатын үйлдвэрийн барилга, байгууламж, технологийн шугамыг ашиглалтанд хүлээн авсан түүхтэй юм.

Тус компани нь 1983 онд “Говь” пүүс, 1993 онд Үйлдвэр худалдааны “Говь” хувьцаат компани гэсэн нэртэйгээр ажиллаж байв. Тус комбинат нь 30 тэрбум төгрөгийн үндсэн ба эргэлтийн хөрөнгөтэй жилдээ 20 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж улсын тесөвт жилдээ 5-6 тэрбум төгрөг оруулж 3 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж байна. Өндөр мэргэжил эзэмшсэн 1500 гаруй ажиллагсадтай, үйлдвэрлэл технологийн 10-аад үйлдвэр цехтэй, 100 гаруй шат дамжлагатай технологийн горимоор ажиллладаг цогцолбор үйлдвэр юм. Тус компани нь “ГОВЬ-2”, барилгын хавтангийн үйлдвэр, 700 тонн хүнсний бүтээгдэхүүн хадгалах хөргүүрийн зоорь, 400 хүний хоолны газар, 80 хүн хүлээн авах амралтын газар, 500 хүнд үйлчлэх сувиллын газар, 42 ортой жуулчны бааз болон хүүхдийн цэцэрлэг-ясли, хот хөдөөгийн салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.



## 17. ЭРЭЛ КОМПАНИ

“Эрэл” компанийн анхны үндэс суурь 1987-1989 онд Өвөрхангай, Төв аймгийн нутагт геологийн иж бүрэн зураглалын ажил явуулж алтны шороон ордыг үйлдвэрийн аргаар олборлож эхэлснээр эхэлсэн байна. Одоо тус компани нь уул уурхай, геологи хайгуул, барилгын материалын үйлдвэрлэл, барилга угсралт, засал чимэглэл, металл боловсруулалт, хөнгөн үйлдвэр, банк, санхүү, даатгал, боловсрол, эрүүл мэнд, хэвлэл мэдээллийн чиглэлээр 20-иод үйлдвэр аж ахуйн нэгж салбартай, 3000-аад ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус компани нь алтны орд ашиглах замаар Өлтийн болон Баянговийн алтны уурхайгаас 1993 оноос одоо хүртэл хугацаанд нийт 11.0 тонн алтыг улсын эрдэнэсийн санд оруулсан байна. Жилд 10000 хавтгай дөрвөлжин метр талбай бүхий орон сууп, иргэний барилга байгууламжийг барих хүчин чадалтай-“Эрэл барилга” компани, барилгын материалын үйлдвэрлэл явуулж жилдээ 30.0 мянган метр куб төмөр болон цул бетон эдлэл, 10.0 мянган м<sup>3</sup> таваарын

зуурмаг үйлдвэрлэх хүчин чадалтай барилгын хийц эдлэлийн үйлдвэр тус тус ажилладаг.

Мөн жилдээ 16.5 сая ширхэг тоосго үйлдвэрлэх хүчин чадалтай тоосгоны үйлдвэр, ажлын нэг ээлжинд 9.0 мянган гоёлын хавтан 5.0 мянган ширхэг ханын блок үйлдвэрлэх хүчин чадалтай элсэн бетон эдлэлийн үйлдвэр, 185.0 мянган тонн 300-500 маркийн Портланд цемент үйлдвэрлэх Дархан хот дахь цементийн үйлдвэр тус тус ажиллаж байна.

“Эрэл ” компанийн машин механизмын бааз металл боловсруулах үйлдвэр, нефть хангамжийн бааз, Эрэл банк, Эрэл судалгааны төв, Эрэл даатгал, Эрэл сургууль, Эрэл эмнэлэг, Монголын мэдээ сонин зэрэг салбарууд нь амжилттай ажиллаж байна.



### 18. СИТИ ТАКСИ КОМПАНИ

Сити такси ХХК нь 1999 оны 8-р сард БНСУ-ын 80 хувийн хөрөнгө оруулалтаар 200 такситайгаар байгуулагджээ. Анхны захиралаар нь Х.Баттулга, дараа нь Х.Болдбаатар нар ажиллаж байсан ба 2001 оны 1-р сараас эхлэн тус компанийн өмчлөл, бүтэц зохион байгуулалт нь өөрчлөгджөк А.Сүхбаатар захиралаар нь ажилласан байна.

2001 оны дундуур БНСУ-ын HYUNDAI фирмээс 800 такси оруулж ирснээр манай улсын анхны 1000 автомашинтай “Сити Такси” ХХК байгуулагдсан байна. Одоо тус компанийн захирал С.Чулуунбаатар ажиллаж байгаа бөгөөд УБ хотод салбар 4 автобаазтай, Дархан Эрдэнэт хотуудад салбараа нээж, үйл ажиллагаа нь өргөжиж байна. Тус компани нь “Хэрэглэгч-Диспетчер-Жолооч-Хэрэглэгч” гэсэн шуурхай үйлчилгээг бий болгож 24 цагийн ажиллагатай Диспетчерийн удирдлагын систем нэвтрүүлэн ажилладаг.

Хоногт дунджаар 1900 гаруй хүн дуудлагын таксигаар үйлчлүүлж байгаа нь УБ хотод нийт такси үйлчилгээний 40 орчим хувийг дангаараа тус компани гүйцэтгэж байна. Тус компани нь “Хэрэглэгчдийг хаанд өргөмжилсөн хамт олон”, “Нийслэлийн хэрэглэгчдийн найдвартай түвш”, “Монголын авто тээврийн тэргүүний байгууллага”, “Манлай компани”, “Олон нийтийн таашаалд нийцсэн таксийн шилдэг үйлчилгээтэй байгууллага” зэрэг өргөмжлөл, цолоор шагнагдсан байна.





*Хөдөлмөрүүк баатар, гасжжамын / 1976 он/*

Өөсөр эхийн эцүү гарас: Ц.Амгалан, Д.Дава, Ц.Дамдинсүрэн /Өвөөнэй/, Х.Хендич, Ч.Нийтийн, Ш.Гонзор, Б.Самбуу, Е.Нийден, Д.Доржкорог, Ш.Шархыг, Шаргадоо Дүнгээ зинэ: С.Гунзаа, Б.Танбат, А.Сүнзээхийн, Д.Мансур, С.Лагва Очир, Б.Дисмэй, С.Онгондор, Д.Раднаахан, Номхай, Гуравдугаар эхийнээд: Ц.Энэд-Аюши, Л.Жамсарайж, Ц.Эрнээндээс, Л.Аюши, Д.Долгор, Д.Мажижирэн, И.Ишорж, Л.Цэрвикжийн, Т.Цэвэлсодон, Арын эхийнээд: Б.Дүцэрсүрэн, С.Тамир, Х.Зандрабал, Сүрэнхор, Шадар, С.Агаан, Б.Норовсүрэн, Б.Гриженбаат, У.Бамбайр

## ХӨДӨЛМӨРИЙН БААТАРУУД



Хөдөлмөрийн баатар  
Д.Шарав



Хөдөлмөрийн баатар  
Х.Хандхүү



Хөдөлмөрийн баатар  
Д.Даш



Хөдөлмөрийн баатар  
Т.Цэвэлсодном



Хөдөлмөрийн баатар  
Ц.Амгалан



Хөдөлмөрийн баатар  
Д.Цэнд-Аюуш



Хөдөлмөрийн баатар  
Ц.Амгалан шавь нарын хамт



Хөдөлмөрийн баатар,  
Төрийн шагналт  
Л.Пэрэнлэй

## ХӨДӨЛМӨРИЙН БААТАРУУД



Хөдөлмөрийн баатар  
Төрийн шагналт  
Б.Гунжилам



Хөдөлмөрийн баатар  
Ё.Норовцэрэн



Хөдөлмөрийн баатар  
Ж.Эрдэнэчимэг



Хөдөлмөрийн баатар  
Р.Чимиidдорж



Хөдөлмөрийн баатар  
Ц.Ганчимэг



Хөдөлмөрийн баатар  
Ш.Цэрэнжаргал



Хөдөлмөрийн баатар  
Д.Дэнсмаа



Хөдөлмөрийн баатар  
Х.Бямбажав



Хөдөлмөрийн баатар  
Д.Балжинням

## АРДЫН ЦОЛТОНГУУД



Ардын жүжигчин,  
Төрийн шагналт  
Д.Мяасирзэв



Ардын жүжигчин  
Л.Жамсранжав



Ардын уран зохиолч,  
Төрийн шагналт  
Ш.Сүрэнжав



Гавьят дасгалжуулагч  
Ц.Шоовдор



Гавьят дасгалжуулагч  
Х.Намшир



Аж чийдвэрийн гавьят  
ажилтан  
Б.Ёндөнжамц



Хошууч генерал  
Ч.Самбуу



Аж чийдвэрийн гавьят  
ажилтан  
П.Доногдорж



Аж чийдвэрийн  
гавьят ажилтан  
А.Зумаа

## АЖ ҮЙЛДВЭРИЙН ГАВЬЯАТ АЖИЛТАН, ТӨРИЙН ШАГНАЛТАНГУУД



Аж цийлдвэрийн гавьяат ажилтан С.Баувусурэн

Монгол улсын аж цийлдвэрийн гавьяат ажилтан, Төр захиргааны ахмад зүтгэлтэн С.Баувусурэн нь Ажилчны районы АДХ-ын депутат, захиргааны гишүүнээр тасралтгүй 13 жил ажиллахдаа районы Ноосны цийлдвэрийн нэгдлийн даргаар цр бүтээлтэй ажиллаж улсын уралдаанд 3 жил дараалан шалгарч төв 4 байгууллагын шагнал цүрд хадгалах дурсгалын тугаар шагнуулж байсан шилдэг түршлэгтэй удирдагч билээ.



Аж цийлдвэрийн гавьяат ажилтан С.Агваан



Аж цийлдвэрийн гавьяат ажилтан Д.Доржсэргэг



Аж цийлдвэрийн гавьяат ажилтан Р.Дашдээлэг



Төрийн шагналтангууд /1988 он/

## ГАВЬЯАТ НИСГЭГЧ НАР



1



2



3



4



5



6



7



8



9



10



11



12



13



14



15



16



17



18

- |                  |                   |
|------------------|-------------------|
| 1. Д.Дэмбэрэл    | 10. Л.Пүрэвсүрэн  |
| 2. Ч.Шагдарсүрэн | 11. С.Танар       |
| 3. Д.Гунгаа      | 12. Т.Сугар       |
| 4. У.Дараавар    | 13. С.Шагдар      |
| 5. Г.Радна       | 14. Б.Сурмаахорол |
| 6. С.Лхагважав   | 15. И.Дамба       |
| 7. Д.Цэрэндорж   | 16. Ж.Цэвээн      |
| 8. Д.Чодин       | 17. С.Очирдорж    |
| 9. С.Тамир       | 18. Р.Батнасан    |

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ТҮҮХ



Монгол улсын урлагын  
гавьяат зүтгэлтэн  
Х.Дамдин



Монгол улсын гавьяат  
багш А.Баяжих



Монгол улсын гавьяат  
багш Л.Галмандах




Монгол улсын гавьяат  
жүжигчин Т.Ариунаа



Монгол улсын гавьяат  
багш Д.Майдаржав



Японы сумо бөхийн дэвжээнд  
Монголын алтан хараацай  
болж амжилттай барилдаж  
“Мэхний их дэлгүүр” хэмээн  
алдаршсан “Мандах наарт уулын  
бүргэд” хэмээх спортын гавьяат  
тамирчин Даваагийн Батбаяр



Монгол улсын гавьяат  
тамирчин  
Ж.Өлзий-Орших

### Хан-Уул дүүргийн танилцуулага

Хан-Уул дүүрэг нь Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын баруун урд хэсэгт Дархан цаазат Богдхан уулын архомой. Туул голын сав нутагт 48466 га нутаг дэвсгэрт оршдог. Нийт нутаг дэвсгэрийн 67.6 хувь нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 11.3 хувь нь хот тосгон, 2.36 хувь нь зам харилцааны сүлжээ, 16.7 хувь нь ой мод, 2 хувь нь ус, 0.63 хувь нь дархан цаазат газар тус тус эзэнэ.

Дүүрэг 470 га авто замын сүлжээтэй бөгөөд түүгээр жилд 3,0 мянган тн.км ачаа, 100000 мянган хүн км зорчигч эргэлттэй байдаг.

Хан-Уул дүүрэг нь засаг захиргааны анхан шатны 14 хороотой бөгөөд тэнд 14700 өрхийн 70400 гаруй хүн амьдардаг. Дүүргийн нутагт жилд дундажаар 581,5 га газарт төмс хүнсний ногоо тариалж, жил бүр 3856,3 - 4610,0 тн ургац авч ихээхэн хэмжээний хадлан тэжээл бэлтгэдэг.

Манай дүүрэгт 5 төрлийн 26,3 мянган толгой мал, 53,6 мянган тахиаг ёсгөн үргүүлж байдгийн дээр булга, хар үнэгний аж ахуй байрладаг.

Хан-Уул дүүрэг нь Монгол улсын аж үйлдвэржилтийн тулгын чuluуг тавилцсан үндэсний эдийн засгийн өлгий нутаг юм.

Дүүргийн хэмжээнд 1200 шахам үйлдвэр, аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд аж үйлдвэрийн жилийн дундаж үйлдвэрлэлт 131,6 тэрбум төгрөг, борлуулалт 115,0 тэрбум төгрөг байна. Энэ нь улсын нийт үйлдвэрлэлтийн 45 орчим хувийг эзэлдэг. Үүнээс: Говь хувьцаат компани 31,7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, агаарын тээврийн МИАТ компани нь жилд дундажаар 260 мянган хүн, 2870,0 тн ачаа тээвэрлэж, нийт 39,7 тэрбум төгрөгийн ажил үйлчилгээ явуулдаг байна. Мөн хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг АПУ ХХК нь 18,0 тэрбум, Атар Өргөө ХК 4,5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.

Дүүрэгт "Эрэл" ХХК, Эрчим хүчний барилга, угсралтын трест, НАБ-н "САН" ххк зэрэг томоохон барилгын байгууллагууд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд жилд дундажаар 6,2 тэрбум төгрөгийн барилга угсаралт, их засварын ажил хийдэг юм.

# ДҮҮРГИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



## ИХТ-ИЙН ХУРАЛ

### ИТХ-ын тэргүүлэгчид

### Ажлын алба

#### Дүүргийн Засаг дарга

Засаг даргын орлогч

#### ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

Санхүү Эдийн засгийн хэлтэс

Нийгмийн хөгжлийн хэлтэс

Тохижилт үйлдвэр үйлчилгээний Хэлтэс

Гадаад харилцаа хэвлэл мэдээллийн алба

Цэрэг иргэний хамгаалалтын штаб

Нийгмийн даатгалын хэлтэс

Татварын хэлтэс

Цагдаагийн хэлтэс

Хөдөлмөр эрхлэлтийн алба

Хот байгуулалт газрын харилцааны алба

Санхүүгийн Хяналт шалгалтын тасаг

Статистикийн хэлтэс

Халамжийн төв

Ахмадын хороо

Эрүүл Мэндийн нэгдэл

Тохижилт үйлчилгээний компани(ҮҮГ)

Хан-Уул хангамж үйлчилгээний Алба

Спорт сургалтын төв


Соёлын төв

Сургалт үйлдвэрлэлийн Төв

Мал эмнэлэг үржлийн Алба

Эрүүл Мэндийн хяналтын алба

## ХАН-УУЛ ДҮҮРЭГ



МОНГОЛ УЛСЫН ХӨДӨӨ АЖ АХҮЙН ИХ СУРГУУЛЬ

Хан-Уул дүүрэг нь шинжлэх ухаан боловсролын өлгий болсон нутаг юм.

Дүүрэгт ерөнхий боловсролын 12 дунд сургууль, улсын болон хувийн 25 их дээд сургууль байдаг бөгөөд тэдгээрт улс ардын аж ахуйн бүхий л салбарт ажиллах боловсон хүчнийг эрдэмтэн багш нар олон улсын жишигт хүрсэн түвшинд бэлтгэн гаргаж байна.

Хан-Уул дүүрэгт Хөдөө Аж Ахуйн бүхий л салбарт ажиллах боловсон хүчнийг бэлтгэдэг цорын ганц дээд сургууль болох Хөдөө Аж Ахуйн Их Сургууль байдаг бөгөөд тус сургуульд төв болон салбарт нь дотоод гадаадын 7000 гаруй оюутан суралцдаг.



ЛАБОРАТОРИЙН ТАНХИМД



МЕХАНИК ИНЖЕНЕРИЙН СУРГУУЛЬ



10 ЖИЛИЙН ДУНД СУРГУУЛЬ



ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛ ЭХЭЛЛЭЭ

Ирээдүйд тус дүүрэг нь эдийн засаг худалдааны чөлөөт бүс болох зорилт тавин ажиллаж байна. Дээрх зорилтын хүрээнд дүүргийн Засаг дарга, түүний Тамгын газрын зүгээс өөрсдөөс шалтгаалах бүхий л боломжийг дайчлан тэдэнд хууль эрх зүйн болон бусад боломжтой бүх талаар туслан ажиллахад бэлэн гэдгийг уламжилахад нэн таатай байна.



МОНГОЛЫН ИРГЭНИЙ АГААРЫН  
ТЭЭВЭР КОМПАНИ



ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ



## KHAN-UUL DISTRICT

Манай дүүрэг нь Монгол улсын үйлдвэрлэл төвлөрсөн хамгийн гол бүс бөгөөд тус дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд нь тус улсын үндэсний нийт бүтээгдэхүүний тодорхой хэсгийг дангаараа үйлдвэрлэдэг юм.

Үндэсний хэмжээний эдгээр компаниудаас гадна АНУ, ОХУ, Англи, Герман, Өмнөд солонгос, Хятад гэх мэт орны хөрөнгө оруулалт бүхий 200 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг бөгөөд дүүргийн зүгээс тэдгээрт үйл ажиллагаагаа хэвийн явуулах бүхий л боломжийг ханган ажиллаж байна.



“Улаанбаатар” хивсний  
үйлдвэр



“Улаанбаатар” хивс



“АПУ”  
хязгаарлагдмал хариуцлагатай  
компани



Бүтээгдэхүүний дээжис

## ХАН-УУЛ ДҮҮРЭГ



“Автобус-1” компани



Үйлдвэрлэлийн явц



Эрмэл Хувьцаат Компани



Атар-Өргөө Хувьцаат Компани



Эрэл ХХК

Нийгмийн эрүүл мэндийн салбар: Дүүргийн нутаг дэвсгэр дээр улсын 3, хувийн 10 эмнэлэг үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тэдгээр нь дүүргийн нийт хүн амд эмнэлгийн туслалцаа үзүүлдэг.

Улаанбаатар хотод хоёр усан эмчилгээний сувилал байдаг нь хоёулаа тус дүүргийн нутаг дэвсгэр дээр оршдог.

“Оргил” рашаан сувилал нь далайн төвшнөөс дээш 1290 метрт орших бөгөөд Богд хан уулын хормойд, Туул голын эрэг дээр байрладаг.




ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

УЛААНБААТАР РАШААН СУВИЛАЛ



Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр дээр түүх соёл, олон нийтийн дурсгалт олон газрууд байдаг юм. Үүний нэг нь тус дүүргийн нутаг дэвсгэр дээр оршдог Богд хааны ордон музей юм.

Тус музейд хадгалагдаж буй зарим нэг бүтээл нь дэлхийн урлагийн суут бүтээлийн жагсаалтад орсон байдаг.



БОГД ХААНЫ ОРДОН МУЗЕЙ

## ХАН-УУЛ ДҮҮРЭГ

**Зочид буудал:** "Palace" зочид буудлын "Жуулчин" ресторан нь шилдэг, шинэлэг үйлчилгээтэй ресторануудын нэг юм. Энэ зочид буудалын ресторан нь хотын төвөөс холгүй, байгалийн үзэмжит газар орших бөгөөд таны ая тухтай байдлыг бүрэн хангах болно.



ЖУУЛЧИН РЕСТОРАН




"PALACE ЗОЧИД БУУДАЛ"



"PEACE BRIDGE" ЗОЧИД БУУДАЛ



"PEACE BRIDGE" ЗОЧИД БУУДАЛ  
РЕСТОРАН



Чингэсийн хүрээ Жуулчны бааз



Хатадын хасаг тэрэг



Гэр-зуслан

“БИОКОМБИНАТ” улсын үйлдвэрийн газрын  
товч танилцууллага


Биокомбинат нь 1973 онд байгуулагдсан юм. Тус үйлдвэр нь мал, амьтаны төрөл бүрийн халдварт өвчнийг оношлох, эмчлэх, сэргийлэх зориулалт бүхий 62 нэр төрлийн эм бэлдмэл үйлдвэрлэж дотоодын зах зээлийн хэрэгцээг бүрэн хангадаг энэ чиглэлийн ганц үйлдвэр юм. Дэлхийн олон оронд одоог хүртэл гарч эдийн засагт их хохирол учруулдаг олон янзын өвчнийг Монгол улсад бүр мөсөн устгах буюу бууруулж байгаа нь энэ үйлдвэрийн бүтээгдэхүүнийг хэрэглэсний үр дүн юм.

## ● ХАН-УУЛ ДҮҮРЭГ



Биокомбинат-Улсын үйлдвэрийн газар

## ХАН-УУЛ ДҮҮРГИЙН БАЙРШЛЫН ЗУРАГ



Нийт талбай	- 48466 га
Газар тариалангийн болон бэлчээрийн газар	- 32767 га
Хот суурин газар	- 5481,50 га
Зам харилцааны сүлжээ	- 1146,6 га
Ой	- 8095 га
Ус	- 308 га

- Газар тариалангийн болон бэлчээрийн газар
- Хот суурин
- Ой
- Байгалийн нөөц
- Сайр
- Туул гол.
- Дүүргийн Хил